

# Засгийн газрын Үйл ажиллагааны хөтөлбөр

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам

2020 оны жилийн эцэс

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2020 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь	
НЭГ. КОВИД-19 ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО								
1	1.1.11. Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад сувиллагч мэргэжлээр суралцагчдад амжилттай нь уялдуулан 100 хүртэл хувийн тэтгэлэг олгоно.	1. Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад сувиллагч мэргэжлээр суралцагчдад сурлагын амжилттай нь уялдуулан Засгийн газрын тэтгэлэг олгоно.	2020 - 2024			Төрийн өмчийн дээд боловсролын байгууллагад сувиллагч мэргэжлээр суралцагчдыг дэмжих зорилгоор: 1/Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 70 дугаар тогтоолд дараах өөрчлөлтийг нэмсэн. Үүнд: Засгийн газрын 2014 оны “Журам, чиглэл шинэчлэн батлах тухай” 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам”-ын “4.1.9-д “Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад сувиллагч мэргэжлээр дээд боловсролын дипломын болон бакалаврын хөтөлбөрт элсэгч нь элсэлтийн ерөнхий шалгалтын 501-ээс дээш оноо авсан бол хичээлийн жилийн эхний улирлын сургалтын төлбөрийг 100 хувь; суралцагч 2.5-3.0 хүртэл голч оноотой суралцсан тохиолдолд сургалтын төлбөрийн 70 хувийг, 3.0 болон түүнээс дээш голч оноотой суралцсан тохиолдолд 100 хувь” хөнгөлнө гэж шийдвэрлэсэн. 2/ Энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтаар “Монгол улсад шаардлагатай тэргүүлэх чиглэлийн мэргэжлийн жагсаалт”-д сувиллагч мэргэжлийг багтаан баталсан. 2020 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар дээд боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхэлж		100%

					буй байгууллагад “сувилахуйн хөтөлбөр”-өөр 2946 оюутан суралцаж байна. 2020 оны улсын төсөвт сувилагч мэргэжлээр суралцагчдад сурлагын онооноос хамааруулж олгох тэтгэлэгт зориулж 5.9 тэрбум төгрөг төсөвлөгдсөн. Журамд заасан шаардлага хангасан 843 оюутанд сурлагын амжилттай нь уялдуулан 625.1 сая төгрөгийн тэтгэлэг олгосон.	
2	1.1.12. Цахим сургалтын платформ бий болгож, цахим агуулга хөгжүүлж, бэлтгэнэ. Зурагт болон интернэтгүй өрх, хүн амыг цахим сургалтад хамрагдах боломжийг бий болгохын тулд тохирсон сургалтын хэлбэр, хувилбаруудыг судалж, бэлтгэнэ.	1. Сургалтын удирдлагын системийг нэвтрүүлж, цахим хичээлийн сан бүрдүүлэн сонголттой хувилбарыг бий болгоно.	2020 - 2024		Сургалтын удирдлагын системийг нэвтрүүлэх ажлын хүрээнд Үндэсний хэмжээнд цэцэрлэг, ЕБС-ийн нийт 90 байгууллагад сургалтын удирдлагын системийг 2020 оны 10 дугаар сараас эхлэн 3 сарын хугацаанд туршин хэрэгжүүлэхээр Ай Си Ти групп, И Эс Эм, Мэксим консалтинг, Амжилт дотком, Эй плас интернэйшнл, Гэрэгэ системс, ТомЁ Эд Тек зэрэг 8 компанитай хамтран ажиллахаар санамж бичиг байгуулан ажиллав. Цахим орчинд видео болон унших, сонсох агуулгыг ашиглах, онлайн буюу видео чат хэлбэрээр сургалт явуулах, суралцахуйн явцыг үнэлэх, хянах хэсэгтэй байх, багшийн бэлдсэн контент буюу агуулга оруулах боломжтой байх, дасгал ажил гүйцэтгэх, шалгалт авах боломжтой байх, удирдлагын тайлангийн хэсэгтэй байх зэрэг шаардлагын дагуу туршилтын ажил амжилттай явагдаж байна. 2020 оны 1 дүгээр сард сургалтын удирдлагын системийг нэвтрүүлнэ. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны “Теле болон цахим хичээл зохион байгуулах тухай” А/165 дугаар тушаалаар улсын хэмжээнд бүх шатны боловсролын байгууллагын танхимын сургалт, үйл ажиллагааг теле хичээл, цахим хичээл хэлбэрт шилжүүлж сургалтын үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж байна. Боловсрол, шинжлэх ухааны яамны Econtent.edu.mn нэгдмэл веб хуудсанд Сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, тусгай хэрэгцээт болон насан туршийн боловсролын сургалтын хөтөлбөрийн дагуу 2020-2021 оны хичээлийн жилд суралцагчдын судлах 4800 цагийн теле хичээл, түүний хуваарь, сурах бичиг болон интерактив цахим хичээлийг тухайн хүүхдийн сургалтын хөтөлбөрийн агуулгад тохирсон байдлаар өөрсдийгөө сорих, хөгжүүлэх дасгал, даалгавруудын хамт тогтмол байршуулан	100%

					ажиллаж байна.	
3	1.1.13. Цахим сургалтын тогтолцоог бий болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	1. Боловсролын болон бусад холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах, дүрэм журмыг шинэчлэн боловсруулна.	2020 - 2024		Боловсролын ерөнхий хууль, түүнийг дагалдан гарах хуулиудад нэмэлт өөрчлөлтийг оруулж хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн УИХ-д өргөн барихаар шийдвэрлэв. Цахим сургалтын тогтолцоог бий болгохтой холбогдуулан сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын тухай хуулийн төсөлд дараах заалтуудыг тусгасан байна. Үүнд: (i) цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сургалт, үйл ажиллагааг танхимын сургалтаас гадна зайн, цахим болон холимог хэлбэрээр зохион байгуулах, (ii) эрх бүхий байгууллагын шийдвэрээр танхимын сургалтын үйл ажиллагааг түр зогсоох тохиолдолд сургалтыг зайн эсхүл цахим хэлбэрээр зохион байгуулах, (iii) ерөнхий боловсролын сурах бичиг нь цахим хэлбэртэй байх, (iv) багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг зайн, цахим хэлбэрээр зохион байгуулах, (v) нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага нь иргэн зайн, цахим хэлбэрээр боловсрол эзэмшихэд зориулж харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэд бүтэц, программ болон техник хангамжийг хариуцан шийдвэрлэх тухай зэрэг болно.	90%
4	1.1.14. Боловсролд зориулсан зардлыг урьдчилан нөөцлөх, орон нутгийн төсвийн орлогыг зарцуулах, боловсролд дутагдаж байгаа зардлыг шийдвэрлэнэ.	1. Боловсролд зориулсан зардлыг нэн тэргүүнд тавьж нөөцлөх, орон нутгийн төсвийн орлогыг дайчлах замаар боловсролд дутагдаж буй зардлыг шийдвэрлэнэ.	2020 - 2024		Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор боловсролын салбар дахь цэцэрлэгийн хүүхдийн хоол, ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдын үдийн цайны болон дотуур байрны хүүхдийн хоолны хэмнэлтийн зардлыг тооцож, эх үүсвэрийг төвлөрүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулав. Үүнд: - Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 181 дүгээр тогтоолын дагуу Боловсрол, шинжлэх ухааны сайдын "Дотуур байрны оюутны хоол хүнс, ариутгал, халдваргүйтлийн санхүүжилтийн тухай" А/153 тоот тушаалаар 764.5 сая төгрөгийн санхүүжилтийг нийт 51 их, дээд сургуульд олгохоор баталж дотуур байранд амьдарч байгаа 10541 оюутны хоол хүнс, ариутгал, эрүүл мэндийн бүтээгдэхүүнээр хангахад зарцуулсан; -Засгийн газрын 2020 оны 188 дугаар тогтоолын дагуу Боловсрол, шинжлэх ухааны	100%

					сайдын 2020 оны “Хүнсний дэмжлэг үзүүлэх тухай” А/162 дугаар тушаалыг баталж, цэцэрлэг, ЕБС-ийн дотуур байрны хүүхдийн хоол хүнс болон бага ангийн суралцагчдын үдийн цайнд зарцуулахаар нөөцөлсөн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг сургууль, цэцэрлэгийн зорилтот бүлгийн нийт 18969 хүүхдэд хүнсний дэмжлэг болгон хүргэснээс орон нутагт 14366, нийслэлд 4603 хүүхэд хамрагдаад байна.	
5	1.1.15. Багш, сурагч, сургуулийн ажилтнуудын эрүүл мэндийн эрсдэлийг тодорхойлж, сурагчийн сургууль завсардалтын эрсдэлийг тооцоолно.	1. Эрүүл мэндийн судалгаанд үндэслэн багш, суралцагчийн хичээл сургалтын хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн зохицуулалт хийнэ.	2020 - 2024		2020 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 1а/3371 дүгээр тушаалаар Эрүүл мэндийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын хамтран баталсан “Боловсролын байгууллагын багш, ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх багцын үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулах ” удирдамжийг баталсан. Тус удирдамжийн дагуу боловсролын байгууллагын багш, ажилтныг багц үзлэгт хамруулах ажлыг 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдрөөс 9 дүгээр сарын 31-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулж, ерөнхий боловсролын сургуулийн 34073 багш, цэцэрлэгийн 28070 багш, ажилтан 100 хувь хамрагдсан байна	100%
<b>ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>						
6	2.2.3. Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн спортын барилга байгууламжийг барина.	8. Захиалгын дагуу барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төсөл боловсруулах ажлыг зохион байгуулна.	2021 - 2024		2020 оны 10 сарын 26-ны өдөр “Боловсрол, шинжлэх ухааны салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн эдийн засаг, нийгмийн өндөр ач холбогдолтой санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах” ажлын жагсаалтыг Барилга, хот байгуулалтын яаманд 1а/2409 албан тоотоор хүргүүлж, нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төсөл боловсруулах ажлыг 2021 оны 3-р сард дуусгах төлөвлөгөөтэйгээр Барилга, хот байгуулалтын яамтай хамтран ажиллаж байна.	90%

7	2.3.1. Яслийн үндэсний тогтолцоог сэргээж 1-2 нас, хүүхэд харах үйлчилгээнд 2-3 насны хүүхдийг хамруулж, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	1. Яслийн үйлчилгээ нэвтрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэн, хамран сургалтыг нэмэгдүүлнэ.	2020 - 2024		2020-2021 оны хичээлийн жилийн статистик мэдээгээр улсын хэмжээнд 12-23 хүртэлх бүлэгтэй төрийн өмчийн 134 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс 2021-2022 оны хичээлийн жилд 12-оос дээш бүлэгтэй төрийн өмчийн 60 цэцэрлэгийн дэргэд байршил, хэрэгцээ шаардлагыг харгалзан яслийн бүлэг нээх, үндэсний тогтолцоог сэргээх ажлыг эхлүүлэх асуудлыг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэн шийдвэр гаргуулах бэлтгэл ханган ажиллсан. Яслийн үндэсний тогтолцоо, хүүхэд харах үйлчилгээний эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Боловсролын хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалд энэ асуудлыг тусган баталж, хуулийн төсөлд эдгээр үйлчилгээнд хамрагдах нас болон бусад зохицуулалтыг тусган боловсруулсан. Яслийн нэг бүлэгт 1-2 насны 15 хүүхэд, 1 багш, 2 туслах багш ажиллуулахаар тооцсон бөгөөд цаашид яслийн орчин, хүний нөөцөд тавигдах нийтлэг шаардлагыг хангасан төрийн бус өмчийн цэцэрлэгт нэг хичээлийн жилд хамгийн багадаа яслийн насны 8000 хүүхэд хүлээн авч, ажил хөдөлмөр эрхлэх хүсэлтэй эхчүүдэд энэ үйлчилгээг сонгон хүүхдээ хамруулах боломж бүрдүүлэх эрх зүйн орчныг бий болгохоор төлөвлөн ажиллаж байна.	70%
8		2. Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулж, бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж, хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	2020 - 2024		2020-2021 оны хичээлийн жилд улсын хэмжээнд 228 хүүхэд харах төвд 2-3 насны 2818 хүүхэд, хүүхэд харах үйлчилгээнд хамрагдсан байна. Үүнээс , ердийн хөгжилтэй 1552, хөгжлийн бэрхшээлтэй 106, хилчдийн 156 хүүхэд байна. Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдсан нийт хүүхдийн 63,3% нь нийслэлд , 37,7% нь орон нутагт байна. Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах, бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг хангасан.	70%
9	2.3.2. Сургуулийн өмнөх	1. Сургуулийн өмнөх	2020 - 2024		Манай Улсын хэмжээнд 2-5 насны 309.6 мянган хүүхэд байгаагаас 2020-2021 оны хичээлийн жилд 1454 цэцэрлэгт нийт	90%

	<p>боловсролд хамрагдах хүүхдийн насыг 3-5 болгож, 5 настай хүүхэд бүрийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангана.</p>	<p>боловсролын үйлчилгээнд хамрагдах насыг 3-5 нас болгон хамран сургалтыг нэмэгдүүлнэ.</p>			<p>247.040 хүүхэд /үүнээс 2 хүртэлх насны 2538, 2 насны 42536, 3-5 насны 201381, 6 насны 585 хүүхэд/ хамрагдаж, хамран сургалт 79,7 хувь болж өмнөх оноос 4,5 хувиар буурсан дүнтэй байна. Энэ нь Коронавирус /Ковид-19/-ын цар тахлын өндөржүүлсэн бэлэн байдлын үед сургалт эхэлсэн, 9 дүгээр сарын 21-ний өдрөөс цэцэрлэгт 2 настай хүүхдийг элсүүлсэн зэргээс шалтгаалан 2020-2021 оны хичээлийн жилд хамран сургалт буурахад нөлөөлсөн. Хамрагдалтыг нэмэгдүүлж, хүүхдийн сургуульд элсэн суралцах бэлтгэлийг хангах зорилтын хүрээнд цэцэрлэгт хамрагдаж чадаагүй 2389 хүүхдийг төрийн бус өмчийн 14 цэцэрлэгт нэмэлтээр элсүүлэн, цэцэрлэгийн байрны түрээсийн зардалд 2020 онд 643.7 сая төгрөг зарцуулсан. Цэцэрлэгт хамрагдах насыг дэлхий нийтийн жишигт нийцүүлэн өөрчилж 3-5 нас болгох, 5 настай хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах асуудлыг Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалд тусган баталж, Боловсролын ерөнхий хуулийн төсөл, түүнийг дагалдан гарах хуулиудын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн УИХ-д өргөн барихаар шийдвэрлэгдээд байна.</p>	
10		<p>2. Сургуулийн өмнөх боловсролд 5 настай хүүхдийг бүрэн хамруулж, сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээг жил бүр хийнэ.</p>	2020 - 2024		<p>2020-2021 оны хичээлийн жилд 5 настай 79,912 хүүхэд байгаагийн 73,375 буюу 92% нь сургуулийн өмнөх боловсрол хамрагдсан. Бэлтгэл бүлгийн багшид зориулсан арга зүйн сургалтын гарын авлага боловсруулж хүргэх, хүүхдийн хөгжлийн онцлогт нийцүүлэн цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн сургалтын орчныг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэхээр төлөвлөн ажиллав. БШУ-ны сайдын 2020 оны А/280 дугаар тушаалаар Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн хөгжил болон сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх журам, шалгуурыг баталж, 2020-2021 оны хичээлийн жилд 5 настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх үнэлгээний тогтолцоог бүрдүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажилласан бөгөөд 2021 онд үнэлгээ хийх ажлыг зохион байгуулна.</p>	90%

11		3. Малчин болон алслагдсан хязгаар бүсэд амьдарч буй өрхийн 3-5 насны хүүхдийг боловсролын үйлчилгээнд хамруулж, хөгжлийг дэмжинэ.	2020 - 2024		2020 оны байдлаар Монгол Улсад 171.655 (нийт өрхийн 19,0 %) малчин өрхийн 2-5 насны 48.367 хүүхэд байна. Үүнээс 2020-2021 оны хичээлийн жилд цэцэрлэгийн үндсэн сургалтад 7.1 мянган хүүхэд, хувилбарт сургалтад 14.7 мянган хүүхэд буюу нийт 31,8 мянга хүүхэд / 65,8% / Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан. ЭЭЛЖИЙН БҮЛЭГ - 99 бүлэгт 2,694 хүүхэд (нийслэл 1, Увс 14, Өвөрхангай 14, Баян-Өлгий 12, Төв 10, Сүхбаатар 16 бүлэг) НҮҮДЛИЙН БҮЛЭГ - 423 бүлэгт, 11,552 хүүхэд ( баруун бүсийн аймгууд 13-24, хангайн бүсийн аймгууд 28-49, төв аймгаас бусад төв, говийн аймгууд 2-13 бүлэг, зүүн бүсийн аймгууд 1-34 бүлэг) ЯВУУЛЫН БАГШ - 29 багш 2,895 хүүхэд (Говь-Алтай 11, Архангай 16, Баянхонгор 13, Өвөрхангай 11, Төв 15) Малчин болон алслагдсан бүс нутагт оршин амьдарч буй өрхийн хүүхэд /хилийн застав гэх мэт/, газар тариалан эрхэлдэг өрхийн хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгох хувилбарт сургалтын журмыг шинэчлэн боловсруулах ажил хийгдэж байна.	70%
12		4. Хамгаалал, дэмжлэг зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн өрхийн хүүхдийг 24 цагийн цэцэрлэгт үе шаттай хамруулж, тэдэнд боловсрол, эрүүл мэнд, хамгааллын цогц үйлчилгээ үзүүлнэ.	2020 - 2024		БСШУСЯ, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран 2020 оны 2 дугаар сарын 17-21-ний өдрүүдэд “Нийслэлд үйл ажиллагаа явуулдаг 24 цагийн цэцэрлэгийн 1700 хүүхдийн гэр бүлийн нөхцөл байдлын түргэвчилсэн үнэлгээ”-г зохион байгууллан ажиллав. Үнэлгээний дүнгээс харахад судалгаанд хамрагдсан 2-5 насны нийт хүүхдийн 17.1 хувь нь хоол тэжээлийн, 14.2 хувь нь хамгааллын, 25.8 хувь нь аюулгүй байдлын дунд буюу өндөр эрсдэлтэй байна. Хамгаалал дэмжлэг зайлшгүй шаардлагатай 43 хүүхдийн судалгааг НХХЯ-ны харьяа ГБХЗГ-т СӨББГ-ын даргын 2020.03.06-ны өдрийн 5/1325 албан тоотоор хүргүүлснээр баг, хорооны түвшинд холбогдох арга хэмжээг авч ажиллалаа. Зорилтот бүлгийн хүүхдийн судалгааны үр дүнд үндэслэн 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрөөс 5 дугаар сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд “Цэвэр гар” аяныг БСШУСЯ, НҮБ-ын Хүүхдийн сан, Солонгосын Хүүхдийн сан, Швейцарын хөгжлийн агентлаг, “Пийпл ин нийд” ТББ хамтран зохион байгуулав. Уг арга хэмжээнд нийслэлийн 24 цагийн болон захын дүүргийн цэцэрлэгт хамрагдаж байсан 1890 хүүхэд, Архангай,	70%

					Булган аймгийн зорилтот бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй 670 хүүхэд, нийт 2560 сургуулийн өмнөх насны хүүхэд, тэдний гэр бүлд коронавирусээс хамгаалах хүнс, ариун цэвэр, боловсролын багцыг хүргэж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж, гарын авлага хүргэн ажилласан байна.	
13	5. Цэцэрлэгийн багшийг тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр мэргэшүүлж, цэцэрлэгт ээлжийн багш ажиллуулна.	2020 - 2024			Япон улсын Жайка байгууллагын “Хөгжлийн бэрхшээлтэй бага насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд тэгш хамруулах үйлчилгээний загварыг туршин хэрэгжүүлэх” төслийг нийслэлийн Хан-Уул дүүргийн 12 дугаар цэцэрлэг, Төв аймгийн Зуунмод сумын Унагалдайн андууд цэцэрлэгт туршихаар сонгон, ажлын төлөвлөгөөг 2020 оны III улиралд төслийн зохицуулах зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталж, үйл ажиллагааг эхлээд байна. Тус ажлын төлөвлөгөөнд Аймаг нийслэлийн боловсролын газрын тусгай хэрэгцээт боловсрол хариуцсан мэргэжилтнүүд, болон дээрх сонгогдсон 2 цэцэрлэгийн багш нарыг тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр тэгш хамруулах арга зүйд суралцуулах, мэргэшүүлэх тухай ажлууд төлөвлөгдсөн бөгөөд бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	70%
14	6. Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих цогц бодлогыг боловсруулан хэрэгжүүлж, салбар дунд хамтын ажиллагааг бэхжүүлнэ.	2020 - 2024			Боловсрол, шинжлэх ухааны яамнаас НҮБ-ын Хүүхдийн Сантай хамтран “Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих цогц бодлого” зөвлөлдөх уулзалтыг 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулж, зөвлөлдөх уулзалтад ЗГХЭГ-ийн шинжээч, Эрүүл мэндийн дэд сайд, ЭМЯ, ХНХЯ-ны холбогдох газрын дарга, мэргэжилтнүүд, НҮБ-ын Хүүхдийн сангийн суурин төлөөлөгч, хөтөлбөрийн ажилтнууд оролцсон. Тус уулзалтаас “Зөвлөмж” гаргасныг холбогдох яамдад хүргүүлэн ажиллав. Тус зөвлөмжийн дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын 2005 оны 116/83/45 дугаар тушаалаар батлагдсан “Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих цогц бодлого”-ыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг байгуулан баримт бичгийг шинэчлэн боловсруулах ажил хийгдэж байна.	70%



15		1. Суралцагчийн сургалтын ахиц, дэвшлийн үнэлгээг тогтмол хийнэ.	2020 - 2024			Суралцагчийн сургалтын ахиц, дэвшлийн үнэлгээг хийх ажил COVID-19 цар тахлын дэгдэлтээс шалтгаалан түр хойшлогдоод байна.	Хугацаа болоогүй
16	2.3.3. Ерөнхий боловсролын сургалтын чанарыг дэлхийн жишигт нийцүүлэх зорилгоор олон улсын PISA үнэлгээнд хамруулж, үндэсний чанарын үнэлгээний тогтолцоог бэхжүүлнэ.	2. Бага, дунд боловсролын чанарыг үнэлэх судалгааг жил бүр зохион байгуулж, хариу арга хэмжээ авна.	2020 - 2024			Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн түвшинг тогтоох сурагчдын мэдлэг, чадвар тэдгээрийн хэрэглээний чадварыг бодитойгоор үнэлж, үндэсний хэмжээнд бага, суурь, бүрэн дунд боловсролын чанарын үнэлгээ хийх зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн 5, 12 дугаар ангийн сурагчдаас түүврийн аргаар 130 сургуулийн 25800 суралцагч, төрийн болон төрийн бус өмчийн бүх сургуулийн 9 дүгээр ангийн ердийн хөтөлбөрөөр, өдрөөр суралцаж буй 43616 сурагчийг хамруулахаар төлөвлөсөн. Чанарын үнэлгээний хүрээнд шалгалтыг 5 дугаар ангийн сурагчдаас математик, монгол хэл, эрүүл мэнд /биеийн тамирын хичээлийг, 9-р ангийн сурагчдаас математик, монгол хэл, хими, англи хэлний хичээлийг цаасан хэлбэрээр, 12 дугаар ангийн сурагчдаас математик, монгол хэл, физик, монголын түүхийн хичээлийг онлайн хэлбэрээр зохион байгуулахаар төлөвлөн ажилласан. Тус ажлыг нийт 3752 багш мэргэжилтний оролцоотой зохион байгуулах байсан боловч Улсын онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 12 дугаар тогтоолоор хойшлогдсон.	70%
17		3. Сурлагын амжилтыг үнэлэх олон улсын (PISA) үнэлгээнд хамрагдана.	2020 - 2024			Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллага (OECD)-аас 3 жил тутамд ерөнхий боловсролын сургуулийн 15 настай хүүхдийг хамруулан зохион байгуулдаг PISA (Programme for International Student Assessment/) сурлагын амжилтыг үнэлэх олон улсын судалгаанд Монгол Улс 2021 онд хамрагдах хэлэлцээрт талууд 2018 оны 07 дугаар сард гарын үсэг зурсан. PISA 2021 судалгаанд манай орны 15 настай сурагчид унших, математик, байгалийн ухааны хичээл болон бүтээлч сэтгэлгээний чадварыг үнэлэх даалгавар гүйцэтгэж, асуулга бөглөнө. Бүтээлч сэтгэлгээг үнэлэх даалгавар шинээр орж байгаа бөгөөд бүтээлч сэтгэлгээний чадварыг үнэлэх шалгалт	Хугацаа болоогүй

					нь нийгэм болон шинжлэх ухаанд тулгамдаж буй асуудлын шийдлийг олох, шинэлэг санаа дэвшүүлэх, өөрийн санааг бичгээр болон загвар бүтээх байдлаар илэрхийлэх чадварыг үнэлэх юм. Судалгаа “туршилтын” болон “үндсэн судалгаа” гэсэн хоёр хэсгээр зохион байгуулагдах бөгөөд гэрээнд заасны дагуу туршилтын судалгаа 2020 онд, үндсэн судалгаа 2021 онд тус тус зохион байгуулагдах байсан. Гэвч дэлхий нийтийг хамарсан коронавируст цар тахлын улмаас туршилтын болон үндсэн судалгаа зохион байгуулах хугацааг зохион байгуулагч талаас тус тус нэг жилээр хойшлуулж /туршилтын шалгалт 2021 оны 3-4 дүгээр сард, 2022 онд үндсэн судалгаа тус тус зохион байгуулах/, гэрээнд өөрчлөлт оруулсан. Туршилтын шалгалтад манай улсын ерөнхий боловсролын 32 сургуулийн 2,700 орчим (нэг сургуулиас 72) хүүхэд, үндсэн шалгалтад 150 сургуулийн (нэг сургуулиас 42) 6,500 хүүхэд тус тус хамрагдана. Шалгалтын үр дүнг Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллага (OECD)-аас 2023 онд зарлана.	
18	4. Их, дээд сургуульд элсэх шалгалтыг сургалтын хөтөлбөрт суурилан зохион байгуулж, ахлах ангийн сургалтын зарим агуулгыг их, дээд сургуулийн багц цаг (кредит)-д тооцуулах зохицуулалтыг бий болгоно.	2020 - 2024		Хугацаа болоогүй.	Хугацаа болоогүй	
19	5. Олон улсад хүлээн	2020 - 2024		Улсын олимпиад зохион байгуулах журмыг шинэчлэн боловсруулж байна. Журамд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн	70%	

		зөвшөөрөгдсөн олимпиадаас медаль хүртсэн ерөнхий боловсролын сургуулийн суралцагч, бэлтгэсэн багшийг урамшуулах эрх зүйн орчин бүрдүүлж, хэрэгжүүлнэ.			олимпиадаас медаль хүртсэн ерөнхий боловсролын сургуулийн суралцагч, бэлтгэсэн багшийг урамшуулах асуудлыг тусган ажиллаж байна. 2019-2020 оны хичээлийн жилд Сингапур улсад зохион байгуулагдсан Мэдээлэл зүйн олон улсын 32 дугаар олимпиадад Монгол Улсаа төлөөлөн оролцож алтан медаль хүртсэн 1 сурагч, Оросын Холбооны Улсын Санктпетербург хотноо зохион байгуулагдсан Математикийн олон улсын 61 дүгээр олимпиадад оролцож медаль болон тусгай байр эзэлсэн 6 сурагчид 20 сая төгрөгийн урамшуулал олгосон.	
20		6. Ерөнхий боловсрол дахь эцэг эхийн үүрэг, оролцоог сайжруулна.	2020 - 2024		Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны “Гэрээний үлгэрчилсэн загвар батлах тухай” А/508 дугаар тушаалаар цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийг аливаа эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх хүрээнд цэцэрлэг, сургууль, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгосон 3 талт гэрээний загварыг баталсан. Энэхүү загварын дагуу цэцэрлэг, сургууль өөрийн онцлогийг тусгаж, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй зөвшилцөх замаар хамтын ажиллагааны гэрээг байгуулан ажиллаж байна. Гэрээ нь цэцэрлэг, сургуулийн орчинд хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүүхдэдээ тавих анхаарал халамж, хараа хяналтыг сайжруулах, хүүхдийн сурч хөгжих эрхийг хангах чиглэлээр талууд хамтран ажиллахад чиглэгдсэн байна.	70%
21	2.3.4. Монголын түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал,	1. Боловсролын сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийж, үзэл баримтлал боловсруулан	2020 - 2024		Боловсрол шинжлэх ухааны сайдын 2020 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А/164 дүгээр тушаалаар “Сургуулийн өмнөх боловсролын сургалт, үйл ажиллагаанд баримтлах чиглэл”-ийг батлан, түүх, үндэсний уламжлал, ёс заншлын талаар мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлэх агуулгыг тусган хэрэгжүүлэх талаар ажиллаж байна. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын	70%

	шударга ёсны үзэл, хандлага болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн агуулгаар баяжуулсан монгол хүний хүмүүжлийг дээдэлсэн, монгол хүний онцлогт тохирсон зан чанар, хүмүүжил, сургалтын хөтөлбөрийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр цэцэрлэг, сургуульд хэрэгжүүлнэ.	түүнийг сургалтын хөтөлбөрт тусгана.			сайдын “Сургалтын хөтөлбөр шинэчлэн батлах тухай” 2019 оны А/390 дүгээр тушаалаар өмчийн хэлбэр харгалзахгүй ерөнхий боловсролын бүх сургуулийн суралцагчдын судлах “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөрийг баталж, ерөнхий боловсролын сургуулийн 1-12 дугаар ангийн суралцагчид 2019 оны 9 дүгээр сараас уг хичээлийг 7 хоногт тус тус 2 цагаар судалж эхэлсэн. Ерөнхий боловсролын нийт сургуульд “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөрөөс гадна монгол хэл, бичиг, уран зохиол, түүх зэрэг суралцагчдыг хүмүүжүүлж, төлөвшүүлэх зорилготой олон сургалтын хөтөлбөрийг зэрэгцүүлэн хэрэгжүүлж байна. Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн менежментийн циклийн дагуу хөтөлбөрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсэн.	
22		2. Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнд тавигдах шаардлагыг шинэчилж, сургалтад ашиглах нээлттэй нөөц материал, цахим агуулгыг бий болгоно.	2020 - 2024		2020 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн А/205, А/206 дугаар тушаалаар 101 нэрийн 1,121,120 ширхэг сурах бичгийн нөхөн хангалтаар хэвлэн нийлүүлэх 3,3 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсан. 2020-2021 оны хичээлийн жилд I-IX ангийн 100 нэрийн 1,071,017 ширхэг сурах бичиг, I-XII ангийн 4 нэрийн 46,500 ширхэг Багшийн журнал, IV-XII ангийн 10 нэрийн Эрүүл мэнд, Иргэний ёс зүйн боловсролын 295,260 ширхэг сурах бичгийг хэвлэж, нийт 110 нэрийн 1,366,277 ширхэг сурах бичиг, Азийн хөгжлийн банкны туслалцаатай хэрэгжүүлж буй "Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл"-ийн санхүүжилтээр нийт 98 нэрийн 2,735,000 ширхэг дунд, ахлах ангийн сурах бичгийг 7,4 тэрбум төгрөгөөр тус тус хэвлүүлэн 21 аймаг, 9 дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн номын санд нийлүүлсэн байна. Мөн тусгай хэрэгцээт боловсролын сургуулийн номын санд брайл сурах бичиг, цахим /daisy-e-pub/ сурах бичиг, цахим /daisy-e-pub/ ном уншигчийг нийлүүлэх ажлыг зохион байгуулсан.	100%
23		3. Үндэстний цөөнхийн хүүхдүүд, лам хүүхдүүд болон	2021 - 2024		Гадаад улсад суралцаж байгаад цар тахлын улмаас эх орондоо ирсэн 8 хүүхдүүдийг өөрийнх нь хүсэлтээр харьяаллын Насан туршийн боловсролын төвд боловсрол нөхөн эзэмшүүлэх сургалтад хамруулан ажиллаж байна. Гадаад улсад амьдарч	90%

		гадаадад гацсан хүүхдүүдэд таатай орчин бүрдүүлж, шаардлагатай сурах материалаар хангана.			байгаа монгол хүүхдэд зориулсан “Монгол хэл, соёлын сургалтын жишиг хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга зүйн сургалтыг Боловсролын хүрээлэнгийн Үндэсний цөөнх болон гадаад дахь монгол хүүхдийн боловсролын судалгааны сектор, Насан туршийн боловсролын үндэсний төв, Багшийн мэргэжил дээшлүүлэх институттэй хамтран 2020 оны 9 дүгээр сард зохион байгуулав. Сургалтад Дархан, Дорноговь, Орхон, Өмнөговь аймгийн болон дүүргийн насан туршийн боловсролын багш нар хамрагдлаа. Багш нар жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам, түвшин бүрт тохирсон бүлэг, нэгж, ээлжит хичээлийг төлөвлөх чиглэлээр мэдээлэл солилцож, зорилтот бүлгийн суралцагчийн монгол хэлний түвшинг оношлох, үнэлэх, эцэг эхтэй хамтран ажиллах, зайнаас сургалт зохион байгуулах, цахим хэрэглэгдэхүүн боловсруулах чиглэлээр чадавхиж байна. Сургалтын модулийн үзэл баримтлал, гарын авлага, материал хэвлэхэд бэлэн болсон.	
24		4. Сургалтын хөтөлбөрт нийцүүлэн сурах бичгийг зохиох, сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2020 - 2024		Хэрэглэгдэхүүний судалгаа хийгдэж байна.	50%
25		5. Эх хэлний сургалтын чанарыг дээшлүүлж, монгол бичгийн сургалт, судалгаа, хэрэглээний орчныг сайжруулна.	2020 - 2024		Сайдын 2020 оны 3 сарын 23-ны өдрийн “Сургалтын бодлого батлах тухай” А/144 тоот тушаалын хавсралтаар “Монгол хэлний сургалтын талаар баримтлах бодлого”-ыг батлан хэрэгжүүлж байна. Хүчин төгөлдөр мөрдөж буй монгол хэл, бичиг, уран зохиолын сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийлээ. МУБИС, МУИС, БМДИ, Боловсролын хүрээлэн, НБГ, ерөнхий боловсролын сургуулийн монгол хэл, бичиг, уран зохиолын хичээлийн багш нарын цахим хурлыг зохион байгуулж, тус хурлаар хүчин төгөлдөр мөрдөж буй монгол хэл, бичиг, уран зохиолын сургалтын хөтөлбөрт хийсэн дүн	70%

					шинжилгээний ажлын явцын үр дүнг урьдчилсан байдлаар танилцуулж, цаашид сургалтын хөтөлбөрийг сайжруулах үзэл баримтлалд тусгах саналын талаар хэлэлцлээ. Иргэдэд зориулсан монгол бичгийн хөтөлбөрийн төслийг боловсруулсан.	
26	6. Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн онцлог, суралцах чадамжид суурилан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний арга зүйг боловсронгуй болгоно.	2020 - 2024			Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны “Жишиг хөтөлбөр батлах тухай” А/305 дугаар тушаалаар Хэл ярианы бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэхэд чиглэсэн “Хэл ярианы хөгжил” хичээлийн сургалтын жишиг хөтөлбөр батлагдсан. "COVID-19"-ийн нөхцөл байдлаас шалтгаалан “Хэл ярианы хөгжил” засан сайжруулах ганцаарчилсан хичээлийн сургалтын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэх 15 видео хичээлийг боловсруулан DVD хэлбэрээр аймаг, нийслэлийн БСУГ-ын мэргэжилтнүүдээр дамжуулан үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлж байна. 2020-2021 оны хичээлийн жилд тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд монгол хэл, математик, нийгэм ахуйн баримжаа хичээлийг бататгах, арга зүйн зөвлөмж боловсруулж, бүх аймаг, дүүргийн боловсролын асуудал хариуцсан нэгжид хүргүүлэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багш нар тус зөвлөмжийг хичээл, сургалтын үйл ажиллагаандаа үр дүнтэй хэрэглэж байна. Хараа, сонсгол, оюун ухааны бэрхшээлтэй хүүхдийн сургалтын төлөвлөгөөг тэдний нас, онцлог, хэрэгцээнд тулгуурлан шинээр боловсруулж, БШУ-ны сайдын 2020 оны А/37 дугаар тушаалаар батлуллаа.	100%
27	7. Үндэстний цөөнх монгол хэл болон эх хэл дээр боловсрол эзэмших, соёл, зан заншлаа өвлөх боломжийг бүрдүүлнэ.	2020 - 2024			“Монгол улсын үндэстний цөөнхийн хүүхдийн хос хэлний сургалтын өнөөгийн байдал, чиг хандлага” Эрдэм шинжилгээний анхдугаар хурлыг 2020 оны 11 дүгээр сард зохион байгуулав. Энэ хурлын зорилго нь хос хэлний сургалтын талаарх судалгаа, шинжилгээг өргөжүүлэх, боловсрол судлаачдыг татан оролцуулах, Монгол улсын үндэстний цөөнхийн хүүхдийн хос хэлний сургалтын цаашдын чиг хандлагыг судалгааны үндсэн дээр тодорхойлоход хувь нэмэр оруулахад чиглэсэн болно. Бага боловсролыг эх хэл (казах, тува) дээр эзэмших боломжоор бүрэн хангаж, 1-9 дүгээр ангийн	70%

					казах хэл, уран зохиолын сурах бичгийн агуулгыг шинэчлэн боловсруулах, нөхөн хангалт хийх, бага ангийн 29 сурах бичгийг казах хэл рүү орчуулах ажлыг тухай бүрд нь улсын төсвийн зардлаар гүйцэтгэж байна. Тува хэлний 1-5 дугаар ангийн сурагч болон багшийн гарын авлагыг НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр хэвлэн сургалтад ашиглаж байна. COVID-19 цар тахлын энэ үед Үндэстний цөөнхийн хүүхдэд зориулсан теле хичээл болон орчуулгыг орон нутгийн 3 телевизээр бичүүлж, Монголын үндэсний олон нийтийн телевиз болон орон нутгийн телевизээр дамжуулан нэвтрүүлж, сурагчдын хүртээл болгосон. <a href="https://www.liveworksheets.com/worksheets/mn?page=18">https://www.liveworksheets.com/worksheets/mn?page=18</a> идэвхтэй хариу үйлдэл бүхий ажлын хуудсыг ажиллуулж байна. Сургалтын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлийн хүрээнд холбогдох сургалтыг НБГ-тай хамтран сургалтыг зохион байгуулсан.	
28	8. Гадаад улсад монгол сургууль, насан туршийн сургалтын төвийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчныг бий болгож, дэмжлэг үзүүлнэ.	2020 - 2024		Гадаад улсад насан туршийн боловсролын төв байгуулах тухай төслийг боловсруулж, тус төсөлд тусгай зөвшөөрөл хэрхэн олгох болон төв байгуулах нийтлэг шаардлагуудыг тусган ажилласан. Төслийг “Хилийн чанад дахь Монголчуудын холбоо” ТББ-аар уламжлан гадаад улсад суугаа монгол хүүхдэд монгол хэл, соёл, түүхийн сургалт явуулж байгаа сургалтын төвүүдэд хүргүүлсэн.	70%	
29	9. Өсвөр насны бүх хүүхдэд нийгэм-сэтгэл хөдлөлийн ур чадварт суралцахад туслах хичээлээс гадуурх чанартай үйл ажиллагаанд	2020 - 2024		Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/199 тоот тушаалаар ерөнхий боловсролын сургуулийн “Хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөр”-ийг баталсан. Хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөр нь орон нутгийн онцлог, тухайн сургуулийн сурагчдын эрэлт хэрэгцээнд тулгуурлан хичээлээр эзэмшсэн мэдлэг, чадварыг бататгах, тэдний авьяас, сонирхлыг дэмжин хөгжүүлэхэд чиглэгдсэн төсөлт ажил, туршилт, дадлага, дугуйлан, клуб хичээллүүлэх зэрэг янз бүрийн хэлбэрээр зохион байгуулахаар	90%	

		хамрагдах хүртээмжийг нэмэгдүүлнэ.			тусгаж оруулснаас гадна хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөмжийг оруулж өгсөн	
30	2.3.5. Мэргэжилтэн бэлтгэх тогтолцоог төгсөгчдийн	1. Судалгаанд суурилсан үндэсний их сургуулийн эрх зүйн орчныг бий болгож, судалгааны их сургуулийг хөгжүүлж эхэлнэ.	2020 - 2024		Азийн хөгжлийн банкны санхүүгийн дэмжлэгтэйгээр судалгааны их сургуулийг хөгжүүлэх төслийн зээлийн гэрээ байгуулсан. Төслийг эхлүүлэхээр бэлтгэл ажил хийгдэж байна. Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн УИХ-д өргөн барихаар шийдвэрлээд байна.	70%
31	мэргэжлээрээ хөдөлмөр эрхлэлттэй уялдуулан судалгаа боловсруулалтын ажлын үр дүнд суурилсан өрсөлдөөнт санхүүжилтийн тогтолцоог бий болгож, судалгаанд суурилсан үндэсний их сургуулийг хөгжүүлнэ.	2. Салбар тус бүрийн хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, тэргүүлэх чиглэл, нэн хэрэгцээтэй хүний нөөцийн эрэлт, хэрэгцээний судалгаа, мэдээлэлд үндэслэн дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэнэ.	2020 - 2024		Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 70 дугаар тогтоолоор “Монгол Улсад шаардлагатай тэргүүлэх чиглэлийн мэргэжлийн жагсаалт”-аар 13 чиглэлийн 37 мэргэжлийн хөтөлбөрийг баталсан. Төрийн болон төрийн бус өмчийн 47 их дээд сургууль тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр сургалтын үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн дундаж үзүүлэлтийг сүүлийн 4 жилийн байдлаар мөшгих судалгаа хийхэд дараах үр дүн гарсан байна. Үүнд: төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн дундаж нь 2016 онд 80.4%, 2017 онд 73.2%, 2018 онд 82.9%, 2019 онд 82.7%-тай буюу тэргүүлэх мэргэжлээр төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн сүүлийн 4 жилийн дундаж нь 81.5% байна	100%
32		3. Их, дээд сургуулийн мэргэжлийн хөтөлбөрийн чанарын үнэлгээг сайжруулана.	2020 - 2024		Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн А/56 дугаар тушаалаар “Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох журам”-ын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санал, дүгнэлт боловсруулах ажлын хэсгийг байгуулж, тус ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн дараах шийдвэр гарсан болно. Үүнд: 1/	100%



					Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн “Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай” А/105, А/106, А/107 дугаар тушаалаар “Монгол дээд сургууль, “Хэл иргэншлийн дээд сургууль”, “Шинэ иргэншил дээд сургууль” -ийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус хүчингүй болгосон. 2/ Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн “Мэргэжил /хөтөлбөр/-ийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай” А/100 дугаар тушаалаар Улаанбаатар эрдэм их сургуулийн 1, Хүрээ мэдээлэл холбоо, технологийн дээд сургуулийн 5, Соёл Эрдэм дээд сургуулийн 1, Түшээ дээд сургуулийн 3, мэргэжил /хөтөлбөр/-ийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус хүчингүй болгосон.	
33	4. Судалгаа, шинжилгээний ажлын санхүүжилтийг нэмэгдүүлж, орлогын олон талт (эндоумент, венч сан) эх үүсвэрийг бий болгоно.	2020 - 2024			Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн УИХ-д өргөн барихаар шийдвэрлээд байна.	50%
34	5. Судалгааны ажлын явц, үр дүнг хянах, хүлээж авах, үнэлэх механизмыг боловсронгуй болгож, үр дүнг шинээр төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх үйл	2020 - 2024			Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын их хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэгдээд байна.	50%

		ажиллагааны гол шалгуур болгох замаар төслийн санхүүжилтийн уян хатан, өрсөлдөөнт тогтолцоог бий болгоно.				
35		6. Судалгааны үр дүнд бий болсон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээл, патент бүрийг урамшуулах тогтолцоог бий болгож, шинэ мэдлэг, патентыг үйлдвэрлэлд нэвтрүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулна.	2020 - 2024		Судалгааны ажлын явц, үр дүнг хянах, хүлээж авах, үнэлэх үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох, олон улсад өндөр чансаатай мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн шилдэг судлаачдыг урамшуулах журмын төсөл боловсруулах шатандаа явагдаж байна.	50%
36	2.3.6. Хөгжлийн тэргүүлэх чиглэлээр суралцаж байгаа болон сургалт, судалгааны ажлын амжилтаар тэргүүлэгч	1. "Боловсролын зээлийн сан"-г орлогын олон талт эх үүсвэр бүхий "Боловсролын хөгжлийн сан" болгож оюутныг дэмжсэн	2020 - 2024		Боловсролын зээлийн сангийн Захирлын 2020 оны 09 дүгээр сарын "Ажлын хэсэг байгуулах тухай" А/64 тоот тушаалаар "Боловсролын хөгжлийн сан"-ийн талаар судалгаа хийж танилцуулах ажлын хэсгийг байгуулагдсан. Ажлын хэсэг БНСУ, Сингапур, Канад, Казахстан, Хятад, Швед, Их Британийн Оюутны зээлийн талаарх судалгаа хийж үр дүнг танилцуулсан бөгөөд 2021 онд судалгааг дахин харьцуулсан байдлаар хийхээр ажиллаж байна.	50%

	оюутнуудад 100 хувь хүртэл сургалтын төлбөрийн тэтгэлэг олгох	үндэсний тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлнэ.					
37	"Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөр" хэрэгжүүлнэ.	2. Засгийн газрын тэтгэлэг, зээлээр гадаадад дээд боловсрол эзэмшигчдийг мэргэжлээр нь хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулан томилон ажиллуулах зохицуулалт хийнэ.	2020 - 2024			Монгол Улсын Засгийн газар, Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага /ЖАЙКА/, Боловсрол, шинжлэх ухааны яамны хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж буй "Инженер, технологийн дээд боловсрол" төслийн Коосэн хөтөлбөрт Япон Улсад амжилттай суралцсан 44, Бакалаврын хамтарсан хөтөлбөрт амжилттай суралцсан 45, нийт 89 төгсөгч эх орондоо ирсэн. Дээрх оюутнуудыг ажлын байранд зуучлах, эзэмшсэн мэргэжил, мэдлэг, ур чадварыг Монгол Улсын хөгжил дэвшилд ашиглах зорилгоор "1000 ИНЖЕНЕР-АЖЛЫН БАЙР" сэдэвт өдөрлөгийг 2 жил дараалан зохион байгуулав. 2020 онд болсон өдөрлөгт нийт 38 төгсөгч эзэмшсэн мэргэжлийн дагуу ажлын байраар хангагдсан нь өмнөх оноос 18 төгсөгчөөр нэмэгдсэн байна. Хоёр улсын Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу 2020-2021 оны хичээлийн жилд шинээр гадаад улсад 1040 оюутан суралцаж байна. Цаашид дээрх ажлыг өргөжүүлэх Засгийн газрын тэтгэлгээр, Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр суралцаж буй иргэдийг оролцуулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажиллахаар төлөвлөж байна.	70%
38		3. Хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэлээр амжилттай суралцагчдыг дэмжих "Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөр"	2020 - 2024			Монгол Улсын Засгийн газраас баталсан "Шилдэг оюутанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг олгох журам"-ын дагуу жил бүр 40 хүртэл оюутанд тэтгэлэг олгодог. 2020 онд энэхүү тэтгэлэгт 120 оюутны материалыг судалж, журмын шаардлага хангасан 30 оюутанд нийт 40.0 сая төгрөг тэтгэлэг олгосон.	100%

		хэрэгжүүлнэ.				
39	2.3.7. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн орон нутаг дахь их сургуулиудыг хотхон хэлбэрт үе шаттайгаар шилжүүлнэ.	1. Бүсийн төв, орон нутаг дахь их сургуулийн хотхоны бүтээн байгуулалтын ажлыг үе шаттай хийнэ. (Дархан, Сэлэнгэ, Орхон, Багануур, Дорнод, Ховд, Завхан)	2020 - 2024		Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн А/48 дугаар тушаалаар “Судалгаанд суурилсан үндэсний их сургуулийг хөгжүүлэх, их сургуулийн хотхоныг байгуулах ажлыг үе шаттай эхлүүлж, хяналт тавьж ажиллах” ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажилтай холбоотой дараах ажлууд хийгдсэн болно. Үүнд: 1.Багануур дүүрэгт “Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, технологийн цогцолбор”-ийг байгуулахаар төлөвлөн 2015 онд ТЭЗҮ, Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж дуусгасан. 2.Дархан-уул аймагт “... бүсийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, бизнесийн төв” хотхоны ажлыг 2021 онд эхлүүлэхээр төлөвлөн 5 яамны төлөөллийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулахаар яамдуудаас санал аван ажиллаж байна. 3.Дорнод аймагт “Зүүн бүсийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, бизнесийн төв”-ийг байгуулахаар ТЭЗҮ, Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2020 онд боловсруулж дууссан бөгөөд бүтээн байгуулалтыг 2021 оноос эхлүүлэхэд бэлэн болсон. 4.Ховд аймагт хотхон байгуулах газрыг шийдвэрлэн, инженер геологийн суурь судалгаа хийгдсэн. 5.Орхон аймагт хотхон байгуулах газрыг шийдвэрлэн, инженер геологийн суурь судалгаа хийгдсэн. 6.Сэлэнгэ аймагт “Хөдөө аж ахуй, био технологийн их сургуулийн ТЭЗҮ, зураг төсөв” боловсруулах чиглэлээр 2021 оны төсөвт 1.2 тэрбум төгрөг батлагдсан.	100%
40	2.3.8. "Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлж, мэргэжлийн стандартыг нэвтрүүлэн, үнэлэмжийг хөдөлмөрийн бүтээмж,	1. Багш мэргэжлийн стандартыг батлуулж, "Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2020 - 2024		АХБ-ны төслийн хүрээнд багшийн ажлыг үнэлэх үнэлгээний шалгуур үзүүлэлтийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж, "Чадварлаг багш" арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулсан. Тус хөтөлбөрийг Засгийн газрын хурлаар хэлэлцүүлсэн ба арга хэмжээг хэрэгжүүлэх Боловсрол, шинжлэх ухааны сайдын шийдвэр гарахад бэлэн болоод байна.	90%
41	хөдөлмөрийн бүтээмж,	2. Багш мэргэжлээр их,	2020 - 2024		Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 70 дугаар тогтоолд дараах өөрчлөлтийг нэмсэн. Үүнд:	100%

	гүйцэтгэлд суурилсан тогтолцоонд шилжүүлнэ.	дээд сургуульд суралцагчдад дэмжлэг үзүүлнэ.			Засгийн газрын 2014 оны “Журам, чиглэл шинэчлэн батлах тухай” 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам”-ын “4.1.5. төрийн өмчийн их, дээд сургуульд багш мэргэжлээр элсэгч нь элсэлтийн ерөнхий шалгалтад 650-750 оноо авсан бол сургалтын төлбөрийг 70 хувь, 751-ээс дээш оноо авсан бол сургалтын төлбөрийг 100 хувь хичээлийн жилийн эхний улиралд; суралцагч 3.0 болон түүнээс дээш голч оноотой суралцсан тохиолдолд сургалтын төлбөрийг үргэлжлүүлэн 100 хувь” хөнгөлнө гэж заасны дагуу төрийн өмчийн их дээд сургуульд Багш мэргэжлээр суралцдаг 1239 оюутанд 1.4 тэрбум төгрөгийн тэтгэлэг олгож дэмжлэг үзүүлсэн.	
42		3. Багшийн ажлын гүйцэтгэлд суурилсан ур чадвар, улирлын үр дүнгийн урамшууллыг бий болгоно.	2020 - 2024		ЗГ-ын 2018 оны “Журам батлах тухай” 382 дугаар тогтоолоор багш нарт ур чадварын болон мэргэжлийн зэргийн нэмэгдлийг олгож байна. Багшийн ажлын гүйцэтгэлд суурилсан ур чадварын нэмэгдэл, үр дүнгийн урамшуулал олгох аргачлалыг шинэчлэн боловсруулах ажил хийгдэж байна.	70%
43		4. Багш мэргэжлийн ур чадвараа тасралтгүй дээшлүүлэх нөхцөлийг сайжруулна.	2020 - 2024		Багшийн мэргэжлийг дээшлүүлэх сургалтыг дараах 3 хэлбэрээр зохион байгуулсан . 1. 2020-2021 ОНЫ МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ҮНДСЭН СУРГАЛТ / давхардсан тоогоор 10880 багш хамрагдсан/ 2. ЗАХИАЛГАТ СУРГАЛТ- /давхардсан тоогоор 1757 хүнд хүргэсэн/ 3. ТӨРӨЛЖСӨН СУРГАЛТ / сургалтад 21 аймаг, 9 дүүргийн нийт 20769 багш, удирдах ажилтан сургалтад хамрагдсан/	100%
44		5. Ерөнхий боловсролын сургуулийн багшийг тусгай	2020 - 2024		МУБИС-ийн Тусгай хэрэгцээт боловсролын тэнхим, “Сонсголгүй боловсрол” ТББ, “Монголын хараагүйчүүдийн холбоо”-той хамтран дохионы хэлний болон брайл бичгийн анхан шатны сургалтын модулийг боловсруулан МУБИС-д багш мэргэжлээр	50%

	хэрэгцээт боловсролын чиглэлээр мэргэшүүлнэ.			суралцаж буй 50 оюутныг хамруулж, гэрчилгээ олгов. Мөн МУБИС-ийн Тусгай хэрэгцээт боловсролын тэнхимийн 27 төгсөгч Тусгай хэрэгцээт багш мэргэжлээр төгссөн. Тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр дараах сургалтуудыг зохион байгуулж, сургалтад ЕБС-ийн багш, сургалтын менежер, нийгмийн ажилтан, мэргэжилтнүүд зэрэг албан тушаалтнууд амжилттай хамрагдаж шаардлагатай мэдлэг ур чадварыг олж чадавхижсан. Үүнд: 1/ “Хэл ярианы хөгжлийн бэрхшээл, түүний онцлог, сургалтын арга зүй” сэдэвт сургалтад 45 багш, мэргэжилтэн 2/ Монголын Аутизмын Холбоо, Гэрэлт Оюун хүүхдүүд ТББ хамтран зохион байгуулсан “Ерөнхий боловсролын сургуульд аутизмтай хүүхдийг тэгш хамруулан сургах нь” сургалтад 96 ЕБС-ийн сургалтын менежер, нийгмийн ажилтан, бага ангийн багш 3/ Японы Хүүхдийг ивээх сангийн “Хүүхэд бүрийг Боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь” төсөлтэй хамтран Ховд, Өвөрхангай аймагт зохион байгуулсан “Тэгш хамруулан сургах боловсрол” үндэсний сургалт зэрэг болно.	
45	6. Сургуулиудын эрүүл мэндийн боловсролын хичээлд суурилан амьдралын ур чадварыг сайжруулна. (багш нарт зориулсан сургалт, сургалтын материал боловсруулалт)	2020 - 2024		Эхний болон 5, 10 дахь жилдээ ажиллаж буй Эрүүл мэндийн хичээлийн багш нарт багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг онлайн болон танхимын хэлбэрээр зохион байгуулав. Коронивирбус (КОВИД-19)-ын цар тахлаас шалтгаалан 2020 оны 01 сарын 27-ны өдрөөс өндөржүүлсэн бэлэн байдал тогтоосон тул танхимын сургалтыг зайн сургалтаар зохион байгуулахаар шийдвэрлэж, зайн сургалтын эхний шат 04 сарын 15-ны өдрөөс 05 сарын 30-ны хооронд /aplus.mn/ зохион байгуулав. Зайн сургалтын 2-р шат 10 дугаар сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 01-ний хооронд /http://esurgalt.itpd.mn/ зохион байгуулж 28 багш хамрагдсан байна. Үндсэн сургалтад хамрагдаагүй 10 багшийг 2020 оны 11 сарын 20-с 12 сарын 25-ны хооронд давтан сургалтад хамруулан ажиллав.	100%
46	7. Багшийн хөдөлмөрийн	2020 - 2024		Багшийн хөдөлмөрийн онцлог, нөхцөл болон буса асуудлыг хөндсөн сэдвээр багш нар болон олон нийт, боловсролын	90%

		онцлог, нөхцөлд үнэлгээ хийж, тэтгэвэр тогтоох насанд өөрчлөлт оруулах боломжийг судлана.			салбарын ажилтан нарын хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Боловсролын ерөнхий хуулийн төсөлд багшийг эрэгтэй-55, эмэгтэйг-50 наснаас тэтгэвэрт гаргах санал оруулан УИХ-аар хэлэлцүүлэхээр бэлэн болоод байна.	
47	2.3.9. Суралцагчдад ээлтэй сургалтын орчныг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх, тусгай хэрэгцээт хүүхдийг ердийн сургууль, цэцэрлэгт сурах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор дараах бүтээн байгуулалтыг хийнэ. Үүнд: - 273 цэцэрлэг ашиглалтад оруулах, - 200 шинэ сургууль ашиглалтад оруулах, - Тусгай хэрэгцээт сургууль, цэцэрлэгийн барилгыг	1. Газар зүйн мэдээллийн системд суурилж боловсрол, шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарын бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтыг төлөвлөдөг болно.	2020 - 2024		Газарзүйн мэдээллийн системд суурилсан сургууль, цэцэрлэгийн хүртээмжтэй, оновчтой төлөвлөлт хийх тогтолцоог бэхжүүлэх хүрээнд Газарзүйн мэдээллийн системийн программ хангамжийн платформыг Боловсролын мэдээллийн технологийн төв хүлээн авч, шаардлагатай нэмэлт хөгжүүлэлтийг хийх ажлыг зохион байгуулж байна. Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн <a href="http://www.investment.edu.mn">www.investment.edu.mn</a> цахим системд өнөөдрийн байдлаар давхардсан тоогоор 448 төсөл арга хэмжээний барилга угсралтын явцын мэдээг оруулаад байна.	70%
48	зорилгоор дараах бүтээн байгуулалтыг хийнэ. Үүнд: - 273 цэцэрлэг ашиглалтад оруулах, - 200 шинэ сургууль ашиглалтад оруулах, - Тусгай хэрэгцээт сургууль, цэцэрлэгийн барилгыг	2. Цэцэрлэг, сургуулийн хүчин чадал, бүтэц, барилгын насжилт, байршлыг оновчтой тогтоож, хүн амын өсөлтийн хэтийн төлөвтэй уялдуулан хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт болон төсөв,	2020 - 2024		Сургуулийн өмнөх боловсролын байгууллага: Улсын төсвийн хөрөнгө оруулалтад батлагдсан шинээр 95,580.1 сая төгрөгийн 59, шилжин хэрэгжиж буй 111,707.9 сая төгрөгийн 62, өмнөх оноос үргэлжлэн хэрэгжиж буй 79,288.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 48 төсөл арга хэмжээ тус тус хэрэгжиж байна. Жилийн эцсийн байдлаар орон нутагт 5265 хүүхдийн хүчин чадал бүхий 42, нийслэлд 4050 хүүхдийн хүчин чадал бүхий 21 буюу нийт 63 цэцэрлэг / нийслэлд 21, орон нутагт-42/-ийн барилга ашиглалтад орсон. 2020 онд барилга угсралтын ажил үргэлжилж байгаа 10%-95% гүйцэтгэлтэй 84 цэцэрлэг байна. Гадаад эх үүсвэр: “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмж сайжруулах төсөл”-ийн хүрээнд дараах 4 цэцэрлэг / 70%-75%- гүйцэтгэлтэй 1, 30-50%-ийн гүйцэтгэлтэй 2, 20-25%-ийн гүйцэтгэлтэй 1 /-ийн өргөтгөлийн барилга угсралтын	100%

	шинэчилж, өргөтгөх, - Жил бүр нүхэн жорлонтой 100-аас доошгүй цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох.	гадаадын зээл тусламжаар 200 сургууль, 273 цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулна.			ажил үргэлжилж байна. Үүнээс: Нэгдсэн Үндэсний байгууллагын Хүүхдийн сангийн хөрөнгө оруулалтаар 2 цэцэрлэгийн барилгын ажлыг эхлүүлсэн. АНУ-ын элчин сайдын яамны санхүүжилтээр 1 цэцэрлэг ашиглалтад орж, 3 цэцэрлэгийн барилгын ажил үргэлжилж байна. Ерөнхий боловсролын сургууль: 2020 оны төсвийн хөрөнгө оруулалтаар 54368 хүүхдийн хүчин чадалтай, 148,5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 127 төсөл арга хэмжээ, өмнөх оноос шилжин хэрэгжих 116,6 тэрбум төгрөгийн өртөгтэй, 39498 хүүхдийн хүчин чадалтай, 82 төсөл арга хэмжээ хэрэгжиж, жилийн эцсийн байдлаар 10680 хүүхдийн хүчин чадалтай 31, гадаадын тусламжаар 6, нийт 37 сургууль / нийслэлд-11, орон нутагт-26 / ашиглалтад орсон. Барилга угсралтын ажил нь үргэлжилж байгаа 92 сургуулийн барилга байна. Гадаад эх үүсвэр: “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмж сайжруулах төсөл”-ийн хүрээнд дараах 10 сургуулийн өргөтгөлийн барилга угсралтын ажил үргэлжилж байна. Хятадын Засгийн газрын тусламжаар 3, Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 3 нийт 6 сургууль ашиглалтад бүрэн орсон.	
49		3. Төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хөдөөгийн цэцэрлэг, сургууль, дотуур байрыг шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгох арга хэмжээ авна.	2020 - 2024		Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн А/84 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг ариун цэврийн байгууламжийн орчин үеийн технологийн шийдлийн судалгаа хийж, 5 төрлийн технологийн шийдлийн зураг, төсөл ажлын даалгаврыг боловсруулж байна. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нийгмийн хариуцлагынхаа хүрээнд энэ асуудлыг шийдвэрлэхэд 100 тэр бум төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлж хамтран ажиллахаа албан ёсоор мэдэгдсэн.	70%



50	4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд оршин суугаа газартаа цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд тэгш хамрагдах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.	2020 - 2024			Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах зорилгоор Архангай, Булган, Дорноговь, Өмнөговь, Сүхбаатар, Завхан, Төв, Хэнтий аймгуудын төвийн сургуульд "Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим" байгуулан нийт 265,2 сая төгрөгийн өртөг бүхий ном, тавилга, тоног төхөөрөмж, тоглоом, туслах хэрэгсэл нийлүүлэх арга хэмжээ авч ажиллалаа. 2020-2021 оны хичээлийн жилд Японы “Хүүхдийг ивээх сан”-гийн “Хүүхэд бүрийг тэгш хамран сургах нь” төслөөс 16 сургууль 5 НТБТ-д 41 сая төгрөгийн өртөг бүхий сургалтын тохирох хэрэглэгдэхүүн нийлүүлсэн байна.	100%
51	5. Тусгай цэцэрлэг, сургуулийн барилгыг өргөтгөх, шинэчлэх, тавилга хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжөөр хангана.	2020 - 2024			Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тохирох орчин, хэрэглэгдэхүүн бүрдсэн 320 хүүхдийн хүчин чадалтай тусгай хэрэгцээт хүүхдүүдийн сургуулийн барилга болон тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэгийн барилгад /Сонгинохайрхан дүүрэг/ 2021-2022 онд хэрэгжихээр тус бүр 4 тэрбум батлагдсан. Тус 2 төсөл арга хэмжээний зураг, төсвийг Барилга, хот байгуулалтын яамнаас хийж байна. “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах зорилгоор Архангай, Булган, Дорноговь, Өмнөговь, Сүхбаатар, Завхан, Төв, Хэнтий аймгуудын төвийн сургуульд "Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим" байгуулан нийт 265,2 сая төгрөгийн өртөг бүхий ном, тавилга, тоног төхөөрөмж, тоглоом, туслах хэрэгсэл нийлүүлэх арга хэмжээ авч ажиллалаа. 2020-2021 оны хичээлийн жилд Японы “Хүүхдийг ивээх сан”-гийн “Хүүхэд бүрийг тэгш хамран сургах нь” төслөөс 16 сургууль 5 НТБТ-д 41 сая төгрөгийн өртөг бүхий сургалтын тохирох хэрэглэгдэхүүн нийлүүлсэн байна.	100%
52	6. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээллийн төв	2020 - 2024			Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны "Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох танхим" байгуулах тухай" А/200 тоот тушаалаар Аймаг дүүргийн Насан туршийн боловсролын 30 төвд мэргэжлийн чиг баримжаа олгох танхим байгуулагдаад байна. Тус танхимын үйл ажиллагааг зохион байгуулахад	90%

		байгуулна.			шаардагдах тоног төхөөрөмж худалдан авах үйл ажиллагаа АХБ-ны санхүүжилтээр хийгдэхээр бэлтгэл хангагдсан. “Насан туршийн боловсролын төвийн багш нарын Мэдээллийн технологийн чадавхийг дээшлүүлэх” сургалтад тус төвийн нийт 30 багш нар хамрагдаад байна. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт 2021 онд зохион байгуулагдахаар бэлтгэл ажил хийгдсэн.	
53		7. Барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төсөл боловсруулах ажлыг зохион байгуулна.	2021 - 2024		Боловсрол, шинжлэх ухааны салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн эдийн засаг, нийгмийн өндөр ач холбогдолтой санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах ажлын жагсаалтыг Барилга, хот байгуулалтын яаманд 2020 оны 10 сарын 26-ны 1а/2409 албан тоотой хүргүүлсэн. Нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төсөл боловсруулах ажлыг 2021 оны 3-р сард дуусгах төлөвлөгөөтэйгээр Барилга хот байгуулалтын яамтай хамтран ажиллаж байна.	90%
54	2.3.10. Цэцэрлэг, дотуур байр, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хоолны зардлыг инфляц, үнийн өсөлттэй уялдуулан 2-оос доошгүй дахин нэмэгдүүлж, ерөнхий боловсролын сургуулийн "Үдийн цай" арга хэмжээг "Үдийн хоол" болгоно.	1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын стандартыг баталж, мөрдүүлэнэ.	2020 - 2024		Ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоолны үйлчилгээг үе шаттайгаар нэвтрүүлэх, бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд: 1/ БСШУС-ын сайдын 2020 оны А/190 дүгээр тушаалаар Хүний нөөц бэлтгэх, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний стандарт, хоол, шим тэжээлийн боловсрол олгох ажлын төлөвлөгөөг баталсан. 2/ Сургууль, цэцэрлэг, дотуур байрны хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үндэсний стандартын төслийн эхний хувилбар бэлэн болсон. Тус стандартад сургуулийн хоол үйлдвэрлэлийн байр, барилга байгууламж, хүний нөөц, тоног төхөөрөмжийн норматив хэмжээ, хоол үйлдвэрлэлийн зохион байгуулалтын үйл ажиллагаа, хоол хүнснээс шалтгаалах хордлогоос урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлын шаардлага болон хамрах хүрээг заасан.	50%
55		2. Ерөнхий боловсролын сургуулийн "Үдийн цай" арга	2020 - 2024		Улсын хэмжээнд 2020-2021 оны хичээлийн жилд нийт ерөнхий боловсролын 839 сургуульд 680,837 хүүхэд суралцаж байгаагаас 1-5 дугаар ангийн 356,904 сурагч "Үдийн цай" хөтөлбөрт хамрагдаж байна. Үдийн хоолны үйлчилгээнд	100%

	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг шүүлтүүртэй ундны цэвэр усаар хангана.	хэмжээг "Үдийн хоол" болгоно.			хамрагдах суралцагчийн тоог урьдчилсан байдлаар гаргахад 2022-2023 оны хичээлийн жилд 1-9 дүгээр ангийн 643678 сурагч, 2023-2024 оны хичээлийн жилд 1-12 дугаар ангийн 806,972 сурагч хамрагдах тооцоотой байна. 2020 оны хөрөнгө оруулалтаар ерөнхий боловсролын сургууль, сургуулийн дотуур байр, цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмжид нийт 4.0 тэрбум төгрөгийг төлөвлөсөн. Сургууль, сургуулийн дотуур байранд 16 нэр төрлийн 84 багц, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 14 нэр төрлийн 100 багц тоног төхөөрөмж худалдан авч, нийлүүлэн бэлтгэл ажлыг хангаад байна.	
56		3. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад сургууль дээр стандартын шаардлага хангасан ундны цэвэр ус уух боломжийг бүрдүүлнэ.	2020 - 2022		Ерөнхий боловсролын 155 сургуулийг ус цэвэршүүлэгчтэй төхөөрөмжөөр хангахаар төлөвлөлт, тооцоог хийсэн	50%
57		4. Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг 2 дахин нэмэгдүүлж, төр, эцэг эх, асран хамгаалагч хамтран хариуцах зарчмаар хэрэгжүүлнэ.	2020 - 2024		БШУЯ-наас 2020-2024 он хүртэл цэцэрлэг, дотуур байрын хүүхдийн хоолны зардлын нормативыг үе шаттайгаар 2 дахин нэмэгдүүлэх тооцоо судалгааг хийгээд байна. Мөн "Сургуулийн өмнөх боловсролын тухай" хуулийн 15.4 дэх заалтыг үндэслэн цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын тодорхой хувь хэмжээг эцэг эх, асран хамгаалагчаас гаргуулах эрхзүйн орчныг 2021 онд бүрдүүлэхээр төлөвлөж байна. Эхний байдлаар төсвийн боломж болон бусад эх үүсвэртэй уялдуулан 2022 оноос хоолны зардлыг 25-30% нэмэгдүүлэх, улмаар 2024 оноос хоолны зардлыг төр 50 хувь, эцэг, эх асран хамгаалагч 50 хувийг хариуцах хариуцлагын зарчимд шилжих, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын хүүхдийн хоолны	50%

					зардлыг төр 100% хариуцах зарчмыг баримтлан эрх зүйн болоод төсөв, санхүүгийн нөөцийг төлөвлөн, хэрэгжүүлэхээр ажиллаж байна.	
58		5. Боловсролын байгууллагын тавилга, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, лабораторийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2020 - 2024		Монгол Улсын 2020 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр ашиглалтад орсон болон өндөр ачаалалтай үйл ажиллагаа явуулж байгаа сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 9.8 тэрбум, ерөнхий боловсролын сургуульд 15.0 тэрбум нийт 24.7 тэрбум төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийг нийлүүлээд байна	100%
59	2.3.11. Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн урлаг, биеийн тамирын хичээлийн агуулга, хөтөлбөрийг сайжруулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангана.	1. Урлаг, биеийн тамирын хичээлийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж, хөгжмийн зэмсгээр сургууль, цэцэрлэгийг хангана.	2020 - 2024		Эдийн засгийн хүндрэлтэй үед боловсролын чанар хүртээмжийг сайжруулах төслийн хүрээнд сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтад хэрэглэж буй сургалтын хэрэглэгдэхүүний өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох түүвэр судалгаа хийж дууссан бөгөөд энэхүү төслийн хүрээнд СӨБ, ЕБС-ийн сургалтын хэрэглэгдэхүүнд тавигдах шаардлагыг боловсруулсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ерөнхий боловсролын сургуулийн спорт зааланд спортын техник хэрэгсэл худалдан авах 650.0 сая төгрөг, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хөгжмийн техник хэрэгсэл худалдан авах 320.0 сая төгрөг, ерөнхий боловсролын сургуульд хөгжмийн зэмсэг, хөгжмийн кабинетэд тоног төхөөрөмж худалдан авах 320.0 сая төгрөг тус тус батлагдсан. Ерөнхий боловсролын сургуулийн спорт зааланд спортын техник хэрэгсэл нийлүүлэх тендерт шалгарсан “Хашхан” ХХК-тай гэрээ байгуулж нийт 35 сургуулийн спорт зааланд холбогдох техник хэрэгслийг, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хөгжмийн техник хэрэгсэл худалдан авах тендерт шалгарсан “Профешнл-Арт” ХХК-тай гэрээ байгуулж 35 байгууллагад хөгжмийн тоног төхөөрөмжийг тус тус нийлүүлсэн.	70%
60	2.3.12. Цахим сургалтын	1. Бүх насны иргэд насан	2020 - 2024		БШУ-ны сайдын 2020 оны 111 дүгээр тушаалаар Насан туршийн боловсролын үндэсний төвийн үйл ажиллагаанд хяналт-	50%

	платформыг хөгжүүлж, цахим сургалтын хөтөлбөрийг боловсруулан, цахим агуулга, цахим хичээл боловсруулан бүх насны иргэдэд насан туршдаа суралцахуйг дэмжих боломжийг бүрдүүлнэ.	туршдаа суралцах боломжийг дэмжих, тэдний бие даан олж авсан мэдлэг, ур чадварыг хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах чиглэлээр насан туршийн боловсролын эрх зүйн орчинг боловсронгуй болгож өргөжүүлнэ.			шинжилгээ, гүйцэтгэлийн аудит хийгдэж, ажлын хэсгээс санал зөвлөмж өгч ажиллав. Насан туршийн боловсролын үндэсний төв болон аймаг дүүргийн төвүүдийн үйл ажиллагаа, чиг үүрэг, санхүүжилтийн тогтолцоог шинэчлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр шийдвэр гаргахаар судалгаа хийгдэж байна.	
61		2. Цахим сургалтын нэгдсэн платформ бий болгож, цахим хичээлийн сан бүрдүүлнэ.	2020 - 2025		Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны “Теле болон цахим хичээл зохион байгуулах тухай” А/165 дугаар тушаалаар улсын хэмжээнд бүх шатны боловсролын байгууллагын танхимын сургалт, үйл ажиллагааг теле хичээл, цахим хичээл хэлбэрт шилжүүлж сургалтын үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж байна. Боловсрол шинжлэх ухааны яамны Econtent.edu.mn нэгдмэл веб хуудсанд Сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, тусгай хэрэгцээт болон насан туршийн боловсролын сургалтын хөтөлбөрийн дагуу 2020-2021 оны хичээлийн жилд суралцагчдын судлах 4800 цагийн теле хичээл, түүний хуваарь, сурах бичиг болон интерактив цахим хичээлийг тухайн хүүхдийн сургалтын хөтөлбөрийн агуулгад тохирсон байдлаар өөрсдийгөө сорих, хөгжүүлэх дасгал, даалгавруудын хамт тогтмол байршуулан ажиллаж байна.	100%
62		2. Багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг	2020 - 2024		Боловсролын сургалтын байгууллагад 1, 5, 10 дахь жилдээ ажиллаж буй багш нар, удирдах ажилтан болон бусад ажилтнуудыг мэргэжил дээшлүүлэх 141 төрлийн онлайн курсэд хамруулсан. Азийн хөгжлийн банкны "Эдийн засгийн	100%

	цахим хэлбэрт шилжүүлж, багшийг мэдээлэл, харилцаа холбооны технологид суурилсан сургалт явуулах арга зүйд сургах ажлыг үе шаттай зохион байгуулна.			хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл"-тэй хамтран цахим сургалтын платформыг өргөжүүлэн хөгжүүлэх, сургалт зохион байгуулах ажлын хүрээнд 10 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд СӨБ, ЕБС-ийн 110 багшид "Онлайн хурал, хэлэлцүүлэг зохион байгуулах арга зүй" сэдэвт сургалтыг зохион байгуулсан.	
63	3. Боловсролын салбарт мэдээллийн системийн инновацийг нэвтрүүлж, нэгдсэн сүлжээг өргөтгөх замаар мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлнэ.	2020 - 2024		Боловсролын салбарын мэдээллийн системийг “Хур” төрийн мэдээлэл солилцооны системтэй холбох ажил амжилттай хэрэгжиж байна. Боловсролын салбарт 2002 онд “Эрдэмнэт сүлжээний төв”, 2012 онд “Боловсролын дата төв, сүлжээний удирдлагын нэгдсэн төв”-ийг тус тус байгуулснаар салбарын мэдээллийн технологийн нэгдсэн сүлжээ үүссэн. Түүнчлэн улсын төсвийн хөрөнгө оруулалт, олон улсын банк, санхүүгийн байгууллага, гадаад орны зээл, тусламжийн санхүүжилтээр төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийг холбосон шилэн кабелийн нэгдсэн сүлжээг 2007-2017 онд үүсгэснээр салбарын мэдээллийн урсгал, контентын хэрэглээний ачааллыг даан ажиллах мэдээллийн технологийн дэд бүтэц бүрдсэн юм. Өнөөдрийн байдлаар төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байрны 90 хувь (738) нь боловсролын мэдээлэл, харилцаа холбооны нэгдсэн сүлжээнд холбогдоод байна. Цаашид төрийн өмчийн сургалтын байгууллагын тус сүлжээнд бүрэн оруулах ажлыг үе шаттай зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	90%
64	4. Шинжлэх ухаан, технологи,	2020 - 2024		Үндэсний статистикийн газрын даргын 2020 оны А/69, А/71 дугаар тушаалаар Шинжлэх ухаан технологийн статистикийн	50%

	инновацийн салбарт мэдээллийн системийн инновацийг нэвтрүүлнэ.			маягт, түүнийг нөхөх заавар, үндсэн үзүүлэлтүүдийг тооцох аргачлалыг тус тус батлуулсан. 2021 онд шинээр батлагдсан аргачлал, маягтад суурилан Шинжлэх ухаан, технологи инновацийн системийн ажлын даалгаврыг боловсруулахаар төлөвлөн, системийг хөгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна.	
65	5. Салбарын үйлчилгээг цахимжуулан иргэд, байгууллагад хүртээмжтэй, түргэн шуурхай, ил тод хүргэнэ.	2020 - 2024		Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн тусгай зөвшөөрөл олгох, сунгах хүсэлтийг 2021 оны 1 дүгээр сараас эхлэн иргэн аж ахуй нэгжээс Боловсролын салбарын мэдээллийн системээр дамжуулан цахимаар хүлээн авах бэлтгэл ажлыг хангаад байна. Боловсролын салбарт суурь, бүрэн дунд боловсролын гэрчилгээ, дипломын лавлагаа, ерөнхий боловсролын сургуулийн Улсын шалгалтын нэгдсэн дүнгийн хуулбар гэсэн 4 төрлийн лавлагааг ТҮЦ машин болон E-Mongolia цахим системээр дамжуулан олгож байна. 2009 оноос хойших ерөнхий боловсролын элсэлт, төгсөлт, журнал хөтлөлт, боловсролын баримт бичиг олголт, элсэлтийн ерөнхий шалгалтын материал түгээлт, засалт, түүний чанарын үнэлгээний судалгаа, багшийн эрхийн бүртгэл, салбарын шагнал урамшууллын хүсэлт, үнэмлэх тэмдгийн нөхөн олголтын хүсэлт зэрэг үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлээд байгаа бол 2010 оноос хойших дээд боловсролын холбогдох баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлээд байна.	90%
66	6. Олон улсын жишигт нийцсэн мэдээллийн технологийн боловсрол, Аутсорсингийн төвийг байгуулж, чадавхыг бэхжүүлнэ.	2020 - 2024		БНЭУ-ын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд олон улсын түвшинд хүрэхүйц мэргэжлийн өндөр ур чадвартай хүний нөөцийг нэмэгдүүлэх, мэдээллийн технологийн гадаад аутсорсингийг хөгжүүлэх зорилгоор олон улсын жишигт нийцсэн мэдээллийн технологийн боловсрол, аутсорсингийн төвийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж шалгарсан компанитай гэрээ байгуулах ажил хийгдэж байна.	50%
67	7. Хиймэл оюун	2020 -		Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Боловсролын зээлийн	100%

	ухаан, их өгөгдөл, өгөгдлийн шинжлэх ухаан, мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр хүний нөөц бэлтгэнэ.	2024			сангийн талаар авах арга хэмжээний тухай” 70 дугаар тогтоолоор “Монгол улсад шаардлагатай тэргүүлэх чиглэлийн мэргэжлийн жагсаалт”-ыг баталсан бөгөөд түүнд Мэдээлэл, харилцаа холбооны технологийн чиглэлээр “Утасгүй холбоо”, “Өгөгдлийн ухаан”, “Системийн аюулгүй байдал” “Хиймэл оюун ухаан” гэсэн 4 мэргэжлээр бакалаврын болон магистрын сургалтад суралцагчдад тэтгэлэг олгохоор шийдвэрлэсэн.	
68	8. Цахим бичвэр, цахим хэл шинжлэлийг хөгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.	2020 - 2024			Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/110 дугаар тушаалаар “Цахим сурах бичиг, сургалтын нээлттэй материалд тавигдах шаардлага” боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд 2021 оны 1 дүгээр сард дүгнэлт нь гарна. Цаашид ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх, цөм хөлтөлбөрийн дагуу цахим контент бэлтгэж нийтийн хүртээл болгох ажлыг үе шаттай хийхээр төлөвлөн ажиллаж байна. Коронавирус (Ковид-19) цар тахлын үед НҮБ-ын хамтарсан төслийн хүрээнд боловсролын салбарын суурь үйлчилгээг дэмжих зорилгоор нийт 104 интерактив, цахим контент бэлтгэн Казак, Тува, Дохионы хэлний хувилбартай хийхээр ажиллаж байгаа бөгөөд одоогийн байдлаар 26 цахим контент бэлтгэн <a href="http://www.econtent.edu.mn">www.econtent.edu.mn</a> хуудсанд байршуулаад байна. Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор баталсан Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III-д цахимд монгол бичгээр бичих стандарт кодчиллын асуудлыг ХХМТГ, СХЗГ эрхлэн хэрэгжүүлэхээр тусгагдсан.	70%
69	9. Цахим агуулга, цахим хичээл боловсруулан насан туршийн боловсролыг бүх хэлбэрээр дэмжинэ.	2020 - 2024			Дүйцсэн хөтөлбөрийн болон насан туршийн боловсролын 10 агуулгын хүрээнд 193 теле хичээлийг аймаг, дүүргийн насан туршийн боловсролын төв, төрийн болон төрийн бус, олон улсын байгууллага, хувь хүмүүстэй хамтран амжилттай зохион байгуулж, бэлтгэсэн. Теле хичээлийн үзэлт, хандалтын тоо: Эфирт цацагдсан нийт 151 теле хичээл давхардсан тоогоор Аймгийн НТБТ-15,659, Дүүргийн НТБТ- 84,154 үзэлт хандалт хийгдсэн байна. 9-12-р ангийн суралцагчдад ажил мэргэжлийн	70%



					чиг баримжаа олгох цахим агуулгын төслийг боловсруулсан, батлагдаагүй байна.	
70		10. Багш бүрийг компьютержуулж, "Ухаалаг сургууль", "Ухаалаг анги" төсөл хэрэгжүүлнэ.	2020 - 2024		Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуульд 1000 ширхэг зөөврийн компьютер олгох 2,000.0 сая төгрөг, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 2200 ширхэг зөөврийн компьютер олгох 4,000.0 сая төгрөгийг тус тус батлуулж, тендерт шалгарсан "Саммит компьютер технологи" ХХК, "Ай ти зон" ХХК-тай гэрээ байгуулж ажилласан. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/266 дугаартай тушаалаар баталсан хуваарийн дагуу 21 аймаг, 9 дүүргийн нийт 1534 байгууллагын 3275 үндсэн багшид зөөврийн компьютер олгох ажлыг хийсэн.	100%
71	2.3.13. Боловсролын хүрээлэнгийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчилж, чадавхыг дээшлүүлнэ.	1. Боловсролын судалгаа, шинжилгээ, сургалт, үнэлгээний байгууллагын чиг үүргийг оновчтой болгож, Багшийн хөгжлийн институт, Боловсролын судалгааны хүрээлэн, Боловсролын чанарын үнэлгээний төв, Насанд туршийн боловсролын хөгжлийн төвийг шинэчлэн зохион байгуулна.	2020 - 2024		Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд "Боловсролын судалгаа, шинжилгээ, сургалт, үнэлгээний байгууллагын чиг үүргийг оновчтой болгож, Багшийн хөгжлийн институт, Боловсролын судалгааны хүрээлэн, Боловсролын чанарын үнэлгээний төв, Насанд туршийн боловсролын хөгжлийн төвийг шинэчлэн зохион байгуулна" гэсэн арга хэмжээг тусган хэрэгжилтийг зохион байгуулж эхлээд байна. Энэ хүрээнд "Боловсролын ерөнхий газар" хэрэгжүүлэгч агентлаг байгуулах үндэслэл, чиг үүрэг, шаардагдах бүтэц орон тоо, төсвийн тооцооллыг боловсруулан саналыг Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар бэлтгэж байна.	70%

72	2.3.14. Төрийн өмчийн их, дээд сургуулиудын судалгааны болон бусад зардалд төрөөс зарим дэмжлэг үзүүлнэ.	1. Төрийн өмчийн их, дээд сургуулиудын судалгааны болон бусад зардалд төрөөс зарим дэмжлэг үзүүлнэ.	2020 - 2024		Боловсрол, шинжлэх ухааны яамнаас шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг үе шаттай бэлтгэх, сургалт, судалгааны ажлыг дэмжих зорилгоор “Эрдэнэс-Тавантолгой” хувьцаат компанитай хамтран ажиллах санамж бичиг байгуулан энэ онд байгалийн ухаан, инженер технологийн чиглэлээр суралцаж буй 8 докторантад 6.0 сая, 5 магистрантад 4.0 сая төгрөгийн тэтгэлэг олгохоор нийт 68.0 сая төгрөгийн санхүүжилт бүхий судалгааны төслийн сонгон шалгаруулалтыг зарлан зохион байгуулсан. Их сургуулийн төгсөх ангийн судлаач оюутнуудын дунд 5.0 сая төгрөгийн шагналын сан бүхий төслийн уралдаан зарлан хэрэгжүүлээд байна.	70%
73	2.3.15. Орон нутаг дахь мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төв, политехник коллеж, их, дээд сургуулиудыг дэмжиж, багш нарт орон нутгийн нэмэгдэл олгож, оюутныг төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцуулна.	1. Орон нутаг дахь их, дээд сургуулиудыг дэмжиж, багш нарт орон нутгийн нэмэгдэл олгож, оюутныг сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцуулна.	2020 - 2024		Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 70 дугаар тогтоолд дараах өөрчлөлтийг нэмсэн. Үүнд: Засгийн газрын 2014 оны “Журам, чиглэл шинэчлэн батлах тухай” 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам”-ын 4 дэх хэсэгт “4.1.9. төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад сувилагч мэргэжлээр дээд боловсролын дипломын болон бакалаврын хөтөлбөрт элсэгч нь элсэлтийн ерөнхий шалгалтын 501-ээс дээш оноо авсан бол хичээлийн жилийн эхний улирлын сургалтын төлбөрийг 100 хувь; суралцагч 2.5-3.0 хүртэл голч оноотой суралцсан тохиолдолд сургалтын төлбөрийн 70 хувийг, 3.0 болон түүнээс дээш голч оноотой суралцсан тохиолдолд 100 хувь” хөнгөлнө гэсэн заалтыг нэмж оруулсан. 2/Энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтаар “Монгол улсад шаардлагатай тэргүүлэх чиглэлийн мэргэжлийн жагсаалт”-д сувилагч мэргэжлийг багтаан баталсан. Дорноговь, Говь-Алтай, Дархан-Уул аймаг дахь анагаахын ухааны салбар сургуулиудад сувилагч мэргэжлээр амжилттай суралцагчид тэтгэлэгт хамрагдсан болно. МУБИС-ийн Архангай дахь Багшийн сургууль, СУИС-ийн салбар Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллеж, Монгол Улсын Консерваторид нийт 88 сая төгрөгийн хөгжмийн хөтөлбөрийн арга зүйн тоног төхөөрөмжийг 7 сард нийлүүлсэн. АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар	100%

					Анагаах ухааны сургуулийн хичээлийн шинэ байрыг улсын төсвийн 6.5 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 2020 оны 10 дугаар сарын 23-нд ашиглалтад оруулсон. Тус хичээлийн байр нь 960 оюутны хүчин чадалтай дөрвөн давхар спорт, урлагийн заалтайгаас гадна сургалтын лаборатори ашиглалтад орсноор оюутнууд дадлагажиж, иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдсэн.	
74	2.3.16. Олон улсад өрсөлдөх чадвартай боловсролын хөтөлбөрийг бий болгох эрх зүйн шинэтгэл хийж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	1. Олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн тоог үе шаттайгаар нэмэгдүүлнэ.	2020 - 2024		Энэхүү зорилтын хүрээнд олон улсад өрсөлдөх чадвартай боловсролын тогтолцоог бий болгох, бодлогын хэрэгжилт, зохицуулалтыг хангах, зураглал, төлөвлөгөө боловсруулж, шаардагдах зардлын хүрээ, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, хяналт шинжилгээний хүрээг тогтоох Техник ажлын зохицуулалтын багийг байгуулсан. Техник ажлын зохицуулалтын баг нь бага, дунд боловсролын багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах, баталгаажуулах, олон улсын хөтөлбөрийн сургалттай төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн тоог нэмэгдүүлэх багш нарын англи хэлний чадавхыг дээшлүүлэх, боловсролын удирдах ажилтны манлайлал, менежментийн чиглэлээр дэмжлэг үзүүлж ажиллана	50%
75	2.4.1.. Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын судалгаа, шинжилгээний чиглэлийг оновчтой болгон, судлаачийн чадавхыг дээшлүүлж, эрдэм шинжилгээ, судалгаанд	1. Салбарын төсвийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоог боловсронгуй болгож, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх замаар салбарын өрсөлдөх чадвар, бүтээмжийг дээшлүүлнэ.	2020 - 2024		Эрдэм шинжилгээний байгууллагын судалгаа хөгжүүлэлтийн ажлыг зөвхөн төсөл хэлбэрээр явуулах нь байгууллагууд өөрийн судалгааны үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх тогтвортой үйл ажиллагаа алдагдах, судалгааны ажлын онол арга зүйн хүрсэн түвшин буурах, судалгаа боловсруулалтын ажлын чанар, эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг сулруулахад хүргэж байгаа тул судалгаа хөгжүүлэлтийн ажлыг төслийн сонгон шалгаруулалтаар, эрдэм шинжилгээний байгууллагын үндсэн чиг үүрэгтэй холбогдсон судалгааг суурь санхүүжилт олгох замаар санхүүжүүлдэг хосолсон тогтолцоог бүрдүүлэх бодлогыг баримталж, Засгийн газарт өргөн мэдүүлээд байгаа Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусган ажилласан.	30%

76	зарцуулах төсвийн зардлыг 4 дахин нэмэгдүүлнэ.	2. Шинжлэх ухаан, технологи, инновацын хамтын ажиллагааг эдийн засгийн хөшүүргээр дэмжсэн эрх зүйн шинэчлэл, зохицуулалтыг хийж, татвар, хөрөнгө оруулалт, зээлийн бодлогоор дэмжинэ.	2020 - 2024		2020 оны 33 дугаар тогтоолоор "Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр", 95 дугаар тогтоолоор "Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл"-ийг тус тус батлуулсан. Ингэснээр инновацийг хөгжүүлэх, суурь, дэд бүтцийг бүрдүүлэн хөгжүүлэх, тэдгээрт ажиллах хүний нөөцийг чадавхжуулах, инновацийн тэргүүлэх чиглэлд хөрөнгө нөөцийг төвлөрүүлэх, төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, түншлэлийг хамтарсан санхүүжилтээр дэмжих, гарааны бизнесийг гааль, татварын бодлогоор дэмжих эрх зүйн орчин бүрдээд байна. 2021 онд "Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл", "Шинжлэх ухааны академийн эрх зүй байдлын тухай хуулийн төсөл"-ийг УИХ-ын чуулганы хуралдаанд хэлэлцүүлж батлуулахаар ажиллаж байна. Мөн "Шинжлэх ухааны паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл", "Судалгааны их сургуулийн тухай хуулийн төсөл", "Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох, тодотгол хийх журмын төсөл"-ийг тус тус батлуулахаар холбогдох бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Эдгээр хууль тогтоомжийн төсөлд судалгаа хөгжүүлэлтийн ажилд зарцуулж буй төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, санхүүжилтийн зарчмыг шинэчлэх, улсын төсвөөс гадна гадаад дотоодын тусгай зорилтот сангууд зэрэг санхүүжилтийн олон эх үүсвэрийг бий болгох замаар оновчтой механизмыг бүрдүүлэн хөгжүүлэх, тэдгээрт шаардагдах хүний нөөц, ялангуяа судлаачдын чадавхийг бэхжүүлэхэд эерэг үр дүнг авчрах зохицуулалтыг тусгасан болно.	70%
77		3. Шинэ мэдлэг, патентыг үйлдвэрлэлд нэвтрүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулах, бүтээгдэхүүн, үйлчилгээ болгон	2020 - 2024		Шинэ мэдлэг, патентыг үйлдвэрлэлд нэвтрүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор БШУ-ны яамнаас жил бүр Инновацийн төсөлд грант олгох, технологийн туршилт зүгшрүүлэлтийн төслүүдийг сонгон шалгаруулах ажлыг хэрэгжүүлдэг. 2020 оны байдлаар өмнөх жилүүдэд батлагдсан инновацийн 5 грант төсөл, технологийн туршилт зүгшрүүлэлтийн 35 төсөл үргэлжлэн хэрэгжиж байна. 2020 онд салбарын хэмжээнд эрдэм шинжилгээний зардал танагдсантай	70%

		хэрэглээнд нэвтрүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулахад хөнгөлөлттэй зээл, грант олгоно.			холбоотой судалгаа боловсруулалтын ажлуудын үр дүн тасалдаж, 2020 оноос эхлэн хэрэгжүүлэхээр сонгон шалгаруулаад байгаа инновацийн грант төсөл, Технологийн туршилт зүгшрүүлэлтийн төслүүд батлагдаагүй байна.	
78		4. Дотоод, гадаадын эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэн, судлаачдын хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, судалгааны үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, дэвшилтэт технологийг нутагшуулахад чиглэсэн санаачилга, хөрөнгө оруулалт, бүтээлч үйл ажиллагааг дэмжих нөхцөлийг бүрдүүлнэ.	2020 - 2024		“Шинжлэх ухаан, инновацийн салбарын байгууллагуудын хамтын ажиллагааны өнөөгийн байдал, хэтийн төлөв” чөлөөт хэлэлцүүлгийг 2020 оны 12-р сарын 11-ний өдөр зохион байгуулав. Хэлэлцүүлэгт их, дээд сургууль, эрдэм шинжилгээний багууллагуудын нийт 50 гаруй төлөөлөл оролцож, салбарын бодлого, эрх зүй, зохицуулалт хөрөнгө оруулалт, дэд бүтэц гэх мэт тулгамдсан асуудлын талаар санал солилцож, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар улсын хэмжээнд хийгдэх бүтээн байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийн судалгааны ажлыг эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлж байх журамд шилжих эрх зүйн орчин бүрдүүлэх тухай санал боловсруулах шатандаа явж байна.	50%
79		5. Үндэсний инновацийн	2020 - 2024		Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 33 дугаар тогтоолоор "Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр"-ийг 3	100%

		тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, инновацийн тэргүүлэх чиглэлийн бүтээгдэхүүн үйлчилгээ, технологи, судалгаа хөгжүүлэлтийн чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.			зорилт 11 арга хэмжээний хүрээнд, 95 дугаар тогтоолоор "Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл"-ийг 5 технологи, 11 салбар чиглэлд хэрэгжүүлэхээр тус тус батлуулсан. Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны 59 дүгээр тэмдэглэлийг үндэслэн "Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	
80		6. Шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг үе шаттай бэлтгэх, чадавхжуулах нэгдсэн бодлогыг хэрэгжүүлж, эрдэм, шинжилгээний ажилтны тоог нэмэгдүүлнэ.	2020 - 2024		ЮНЕСКО-ийн 39 дүгээр Ерөнхий бага хурлын чуулганаар батлагдсан "Шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний ажилтнуудад зориулсан зөвлөмж"-ийг монгол хэлнээ орчуулан, хэрэгжилтийн тайланг боловсруулж ЮНЕСКО-д 2021 оны 1 дүгээр улиралд хүргүүлэхээр ажиллаж байна. Шинжлэх ухаан технологийн салбарын статистикийн үндсэн үзүүлэлтийг тооцох аргачлалыг боловсруулан, Үндэсний статистикийн хорооны даргын 2020 оны 12 сарын 18-ний өдрийн А/69 тоот тушаалыг батлуулсан. Шинжлэх ухаан технологийн салбарын захиргааны болон албан ёсны статистикийн мэдээний маягт (захиргааны 10, албан ёсны 11 маягт), түүнийг нөхөх зааврыг шинэчлэн боловсруулж, Үндэсний статистикийн хорооны даргын 2020 оны 12 сарын 18-ний өдрийн А/71 болон А/72 тоот тушаал болон БШУ-ны сайдын 2020 оны 12 сарын 30-ны өдрийн А/215 тоот тушаал батлагдсан. Цаашид шинээр батлагдсан аргачлал, маягтад суурилан Шинжлэх ухаан, технологийн салбарын удирдлагын нэгдсэн системийн ажлын даалгаврыг боловсруулахаар төлөвлөн, системийг хөгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна.	50%

81	2.4.2. Шинжлэх ухаан, технологи, инновацын чиглэлээр шинжлэх ухааны парк,	1. Шинжлэх ухааны паркийн эрх зүйн орчныг бүрдүүлж, парк байгуулах ажлыг үе шаттай зохион байгуулна.	2020 - 2024		Шинжлэх ухааны паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулж, хуулийн төсөлд 13 яамдаас санал авсан. Хуулийн төсөлд саналыг тусган эцэслэж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Монгол Улсад ШУПарк байгуулах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын /техникийн/ даалгаврыг боловсруулж, урьдчилсан судалгааг хийсэн. Монгол улсад Шинжлэх ухааны парк байгуулах байршлыг Барилга хот байгуулалтын яамнаас Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг даган хөгжих Шинэ Зуунмод /Аэросити/-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгуулав.	70%
82	хүрээлэнгийн цогцолбор, уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн барилгын ажлыг эхлүүлж, олон улсын стандартад нийцүүлнэ.	2. Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн цогцолборыг олон улсын стандартад нийцүүлж, нээлттэй, салбарын дундын нэгдсэн, төрөлжсөн лабораториудыг байгуулах замаар эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулийн судалгааны нэгдмэл байдлыг хангана.	2020 - 2024		Улсын төсвийн 94.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар баригдах Шинжлэх ухаан, инновацийн төвийн кластерийн барилгын ажлыг 2020 оны 10 дугаар сард эхлүүлсэн. Уг кластер нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнд 4,8 га талбайд баригдах ба 74,300 м2 ашиглалтын талбай бүхий үндсэн 7 хэсэг барилга, байгууламжаас бүрдэх бөгөөд цогцолборыг 2022 онд ашиглалтад оруулна. 2020 оны улсын төсөвт 3 тэрбум, 2021 оны улсын төсөвт 24 тэрбум төгрөг батлагдсан. Уг цогцолбор нь олон улсын стандартад нийцсэн нээлттэй, салбарын дундын нэгдсэн, төрөлжсөн лабораториудтай байх бөгөөд Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгүүд болон бусад их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудын 3300 орчим эрдэмтэн судлаач, албан хаагчид ажиллах хүчин чадалтай шинжлэх ухаан, технологи, инноваци, танин мэдэхүйн төв болох юм.	100%
83		3. Уламжлалт анагаах ухаан, технологийн	2020 - 2024		Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн үйл ажиллагааг өргөтгөх зорилгоор одоогийн эмнэлгийн суурин дээр “Дорно дахины уламжлалт мэдлэг ухааны судалгаа, сургалтын	70%

		хүрээлэнгийн барилгыг барина.			олон улсын цогцолбор” -ыг барихаар төлөвлөж, уг барилгын загвар /эскиз/ зураг, архитектур төлөвлөлтийн болон барилгын ажлын зураг төсөл боловсруулах даалгаврыг батлуулж Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөнд тусгуулаад байна. Дэд бүтэц, цахилгаан, дулаан, усны хангамжийн асуудлыг шийдвэрлэн байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийлгэсэн. Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн шинэ барилгын зураг төслийг хийх ажлын санхүүжилтийг 2021 оны Барилга хот байгуулалтын сайдын төсвийн зураг төсөл боловсруулах зардлаас гаргах саналыг тус яамнаас хүргүүлээд байна.	
84		4. Эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулийн хамтарсан судалгааны үндэсний төвүүдийг байгуулж, хөрөнгө, нөөцийг төвлөрүүлнэ.	2020 - 2024		Засгийн газрын 2018 оны 282 дугаар тогтоолоор баталсан Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр АХБ-аас бодлогын зээлээр дэмжих шийдвэр гарсан. Азийн хөгжлийн банкны 30 сая ам.долларын хөнгөлөлтэй зээлээр 2021-2024 онуудад хэрэгжих “Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх” төслийн хүрээнд шинжлэх ухааны байгууллагуудын эрдэм шинжилгээ, туршилт судалгааны ажлын үр дүн, судалгааны бүтээлүүдийг их, дээд сургуулиудын сургалтад ашигладаг механизмыг бүрдүүлж, сургалт, судалгаа, инновацийн төвүүдийг их, дээд сургуулиудад байгуулахаар ажиллаж байна.	50%
85	2.4.3. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эдийн засаг, нийгмийн хөгжилд өгч байгаа үр өгөөжийг шалгуур болгон санхүүжүүлдэг өрсөлдөөнт тогтолцоонд	1. Их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад технологийн инкубатор, технологи дамжуулах төв байгуулах ажлыг үргэлжлүүлнэ.	2020 - 2024		Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 19 дүгээр тогтоолоор Монгол Улсад өндөр технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, шинжлэх ухааны паркийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэйгээр “Шинжлэх ухааны паркийн захиргаа” шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдэл байгуулагдсан. Тус байгууллагын Маркетинг, инновацийн алба, Технологи дамжуулах алба, Технологи инкубаторийн алба нь Монгол-Хятадын хамтарсан “Монгол улсын инкубаторын үйл ажиллагааны хөтөлбөр болон мэдээллийн серверийн бүтээн байгуулалт”, “Монгол-Хятадын хамтарсан технологи дамжуулах платформ байгуулах” төслийг хэрэгжүүлж, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаж байна. “Шинжлэх ухааны	70%



	шилжүүлж, нэгдсэн, төрөлжсөн, нээлттэй лабораторийг байгуулан салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.				паркийн эрх зүйн байдлын тухай хууль"-ийн төслийг боловсруулж, батлуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	
86	2. Салбар дундын нэгдсэн, төрөлжсөн лабораториудыг байгуулах ажлыг үргэлжлүүлнэ.	2020 - 2024			Салбар дундын нээлттэй, сүлжээ лабораторийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор сургалт, судалгаа, шинжилгээ, хяналтын нийт 54 байгууллагын 311 лабораторийн судалгаа хийж, судалгаагаар улсын хэмжээнд 164 лаборатори итгэмжлэгдсэнээс их сургууль хүрээлэнгийн харьяа 13 лаборатори (7.9%), үндэсний болон олон улсын хэмжээнд итгэмжлэгдсэн бол салбар дундын нээлттэй лабораторийн сүлжээнд нэгдэх боломжтой яам, агентлаг, тусгай газрын 11 лаборатори итгэмжлэгдсэн байна. Судалгааны үр дүнд үндэслэн “Шинжлэх ухааны салбар дундын нээлттэй лабораторийн үйл ажиллагааг зохицуулах” журмын төслийг боловсруулан ажилласан.	50%
87	3. Монгол судлалыг олон улсын болон бүс нутгийн хүрээнд өргөжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, бэхжүүлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	2020 - 2024			Боловсрол, шинжлэх ухааны сайд болон Соёлын сайдын хамтарсан А/128, А/29 дүгээр тушаалаар “Монгол дахь үндэсний ижилсэл, эв нэгдлийн тулгамдсан асуудлууд” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, монгол судлалын уншлагын танхимд дэлхийн монгол судлалын шилдэг бүтээлийн сан бүрдүүлэх болон эмхэтгэл, каталоги хэвлүүлэх зэрэг арга хэмжээний зардлыг баталсан бөгөөд Соёлын яамтай хамтран тушаалын хэрэгжилтийг ханган ажиллав. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны 04 дугаар сарын 23-ны өдрийн А/202 дугаар тушаалаар Олон улсын Монгол судлалын холбооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, монгол судлалыг сурталчлах зардлыг баталснаар олон улсын Монгол судлалын холбооноос BULLETIN, Монголика” олон улсын сэтгүүлийг англи хэл дээр хөрвүүлэн хэвлүүлж, монгол судлалын төвүүдийг мэдээллээр ханган ажилласан. Монгол судлалыг хөгжүүлэх чиглэлээр “Монгол судлаачдын өв” нэгдсэн сан хөмрөг үүсгэх, “дэлхийд тархсан өв”, “Монгол орон Монголчууд” цуврал судалгаа боловсруулалтын ажил хийгдэж, төслийн үр дүнг хэвлүүлэн сурталчилж, олон нийтийн хүртээл	90%

					болгосон. Коронавирус /Ковид-19/-ын цар тахлын улмаас Олон улсын монголч эрдэмтдийн 12 дугаар их хурлыг Монгол Улсад зохион байгуулагдах ажил тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон.	
88	4. Шинжлэх ухаан, технологи, инновацийн статистик мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог олон улсын нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгоно.	2020 - 2024			Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа болон судалгаа, хөгжүүлэлтийн ажил, түүнтэй холбоотой статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлалыг олон улсад мөрдөж буй Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Фраскатиин гарын авлагын дагуу боловсруулан Үндэсний статистикийн газрын Арга зүйн байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж Үндсэний статистикийн газрын даргын 2020 оны А/69, А/71 дугаар тушаалаар ШУТ-ийн статистикийн маягт, түүнийг нөхөх заавар, үндсэн үзүүлэлтүүдийг тооцох аргачлалыг тус тус батлуулсан.	90%
89	5. Шинжлэх ухааны мэдлэг, инновацийн соёлыг түгээн дэлгэрүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж, танин мэдэхүйн агуулга бүхий контент бүтээх ажлыг дэмжих замаар шинжлэх ухаанч соёлыг төлөвшүүлнэ.	2020 - 2024			Монгол Улсын Засгийн газрын 11 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанаар “Баргил тех” ХХК-ийн “Эко барьцалдуулагч” бүтээлд “Шилдэг инновацийн бүтээгдэхүүн”, “Ворлд плас дигитал” ХХК-ийн “Ворлд плас аппликэйшн” бүтээлд “Үйлчилгээний салбарын шилдэг инноваци”-ийн шагналыг олгож, тус бүр 30 сая төгрөгөөр шагнаж урамшуулсан. Инновацийн соёлыг түгээн дэлгэрүүлэх, инновацийн үйл ажиллагааг урамшуулах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлын төлөвлөгөөний төслийг боловсруулсан. 2021 онд батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулна.	30%
ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО						

90	3.4.6. Баян-Өлгий, Увс, Ховд, Өвөрхангай, Архангай, Баянхонгор, Өмнөговь, Дорнод, Завхан аймгуудад аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлж, отоглох цэг, авто зам дагуу үйлчилгээний цогцолборуудыг байгуулна. Говийн бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	4. Монголын говьд шинжлэх ухаан, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх MARS-V төслийг хэрэгжүүлнэ. /Survival буюу даван туулж, тэсэж гарах чадвар олгох мэргэжлийнхэн болон сонирхогчдод зориулсан MARS-V академи байгуулах/	2020 - 2024			"Mars on Earth" буюу "Дэлхий дээрх Марс" олон улсын хурлыг 2020 оны 11 дүгээр сард Төрийн ордонд зохион байгуулахаар төлөвлөж байсан боловч гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын улмаас хойшлогдсон.	Хугацаа болоогүй
<b>ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО</b>							
91	4.2.5. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид	3. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд өөрчлөлт оруулна. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг өдөр тутмын үйл ажиллагаандаа	2021 - 2024			Боловсрол, шинжлэх ухааны яамны шууд харьяа 73 байгууллагын 29559 төрийн албан хаагчидтай бөгөөд 26 байгууллагын төрийн үйлчилгээний 72 албан хаагч ёс зүйн зөрчил гаргасны улмаас хууль тогтоомжийн дагуу сануулах, цалинг хувиар бууруулах, ажлаас чөлөөлөх шийдвэрүүдийг гаргасан байна. Эдгээр ёс зүйн зөрчил гарсан албан хаагчид нь нийт албан хаагчдын 0.24 хувийг эзэлж байна. БШУЯам болон түүний харьяа байгууллагууд нь хууль, тогтоомжийн дагуу “Ёс зүйн зөвлөл”-ийг байгуулан ажиллаж байгаа бөгөөд төрийн захиргааны байгууллагын албан хаагчдаас 2020 онд ёс зүйн зөрчил гаргаагүй байна.	100%

	хүлээлгэх хариуцлагыг чангатгана.	хэрэгжүүлэх талаар сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.				
92	4.3.2. Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох цогц арга хэмжээг хэрэгжүүлснээр гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулж, нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангана.	2. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг криминологи дүн шинжилгээ судалгаанд суурилан явуулж гадаад дотоодын байгууллагуудтай хамтран ажиллана. Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах арга хэмжээ авна.	2021 - 2024		БШУ-ны яам, Эрүүл мэндийн яам, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Монголын үндэсний олон нийтийн телевиз, радио, Нэгдсэн үндэсний байгууллага, Хүүхдийн сан, Сургуулийн нийгмийн ажилтны нийгэмлэг хамтран “Хүүхэдтэй боловсрол” нийгэм, сэтгэл зүйн нөлөөллийн 2 сарын аяныг зохион байгуулсан. Тус аяны хүрээнд нийгэм-сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх чиглэлээр “Шинэ коронавирусийн дэгдэлтийн үед сэтгэлзүйгээ хамгаалъя” 5 төрлийн зөвлөмж, Youtube, Tiktok, Facebook, Instagram зэрэг сүлжээний олон суваг платформуудыг ашиглан “ЧИ ГАНЦААРАА БИШ” аян, “Чи ганцаараа биш” тикток челленж, хүүхэд, өсвөр үеийнхэнд чиглэсэн “Коронагийн үеэр бидний сэтгэлзүйд гарч буй өөрчлөлтүүд” видео шторк, “Коронагийн эсрэг хамтдаа” видео шторк, “Эергээр сэтгэн бодох нь”, “Тайвшруулах амьсгалын дасгал”, “Онлайн орчинд аюулгүй байх нь” гурван цуврал харандааны адал явдал видео гэх мэт нийгэм-сэтгэлзүйн асуудлаар нөлөөллийн ажлуудыг дээрх байгууллагуудтай хамтран хийсэн.	90%